




ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН **2023 ОНЫ ТАЙЛАН**



АГУУЛГА

НЭГ. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

ХОЁР. ШҮҮХИЙН СУРГАЛТЫН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

1. Сургалтын хөтөлбөрийн хороо
2. Шүүгчийн сургалт
3. Цахим сургалт

ГУРАВ. ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

1. Захиргааны эрх зүйн сектор
2. Эрүүгийн эрх зүйн сектор
3. Иргэний эрх зүйн сектор
4. Сектор хоорондын хамтарсан судалгаа

ДӨРӨВ. ШҮҮХ, ШҮҮГЧ, ОЛОН НИЙТИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

1. Шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэх чиг үүргийн хүрээнд
2. Олон нийтийг мэдээллээр хангах, чиг үүргийн хүрээнд
3. Хэвлэн, нийтлэх чиг үүргийн хүрээнд

ТАВ. “МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ” СЭТГҮҮЛ ЭРХЛЭН ГАРГАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

ЗУРГАА. ШҮҮГЧИЙН СУРГАЛТЫН ЦАХИМ СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭЛТ

ДОЛОО. ХҮРЭЭЛЭНТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ШҮҮГЧ НАР

1. Шүүгч-судлаач
2. Шүүгч-сургагч багш нар

НАЙМ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

1. Хамтын ажиллагааны санамж бичиг
2. Гадаад айлчлал
3. Хүрээлэнгийн байранд зочилсон гадаад улсын төлөөлөл

ЕС. БУСАД

1. Журмын төсөл бэлтгэх ажлын хүрээнд
2. Дотоод сургалтын чиг үүргийн хүрээнд
3. Судалгааны санг төрөлжүүлэн, ангилах ажлын чиг үүргийн хүрээнд
4. Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцох хүрээнд
5. Бусад хурал, хэлэлцүүлэг, сургалтад хамрагдсан байдлын хүрээнд
6. Илтгэл бичих, сургалт бэлтгэх, албан бичигт хариу хүргүүлэх ажлын хүрээнд

Хүснэгтийн жагсаалт

1.	Хүснэгт 1. ШССМХ-д 2023 онд ажилласан хүний нөөцийн мэдээлэл
2.	Хүснэгт 2. 2023 онд хамтран ажилласан гишүүд, шүүгч нар
3.	Хүснэгт 3. Сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хорооны бүрэлдэхүүн
4.	Хүснэгт 4. СХХ-ны хуралдааны мэдээлэл
5.	Хүснэгт 5. Баталсан болон дахин хэлэлцэхээр хойшилсон
6.	Хүснэгт 6. Танхимаар зохион байгуулсан сургалт
7.	Хүснэгт 7. Цахим системд байршуулсан сургалт
8.	Хүснэгт 8. Цахим системд байршуулсан видео хичээл-2022 он
9.	Хүснэгт 9. Цахим системд байршуулсан видео хичээл-2023 он
10.	Хүснэгт 10. 2023 онд видео хичээл бэлтгэн цахим системд байршуулахаар төлөвлөсөн хэдий ч бичлэг хийгдээгүй байгаа сургалт
11.	Хүснэгт 11. Санал ирүүлсэн шүүх
12.	Хүснэгт 12. 2023 онд айлчлал хийсэн улсууд
13.	Хүснэгт 13. Шүүхийн судалгааны төвөөс зохион байгуулсан дотоод сургалтууд

Графикийн жагсаалт

1.	График 1. 2022 болон 2023 он батлагдсан хөтөлбөрийн тоо харьцуулалт
2.	График 2. Баталсан болон хойшилсон сургалтын хөтөлбөрийн хувь
3.	График 3. Баталсан сургалтын хөтөлбөрийн ангилал
4.	График 4. Танхимаар зохион байгуулсан сургалт
5.	График 5. Танхимаар зохион байгуулсан сургалтын ангилал
6.	График 6. 2022, 2023 оны цахим сургалт
7.	График 7. Цахим сургалтын ангилал
8.	График 8. Цахим сургалтын ангилал
9.	График 9. Цахим сургалттай танилцсан дундаж хувь
10.	График 10. Шүүхийн судалгааны төвийн 2023 онд хийж гүйцэтгэсэн судалгаа
11.	График 11. Секторуудын бие даан хийсэн судалгаа
12.	График 12. Захиалгат судалгааны захиалагчид
13.	График 13. Өмнөх онуудад судалгааны төвийн хийж гүйцэтгэсэн судалгаанууд
14.	График 14. Шүүгчийн захиалгын дагуу Захиргааны эрх зүйн секторын гүйцэтгэсэн судалгааны төрөл
15.	График 15. Шүүгчийн захиалгын дагуу Эрүүгийн эрх зүйн секторын хийсэн судалгааны төрөл
16.	График 16. Шүүгчийн захиалгын дагуу Иргэний эрх зүйн секторын хийж гүйцэтгэсэн судалгааны төрөл
17.	График 17. Өмнөх онд бэлтгэсэн шүүхийн шийдвэрийн хураангуйн тоо
18.	График 18. ШССМХ-ээс гаргасан шүүхийн шийдвэрийн тойм, хураангуй
19.	График 19. Хураангуйлсан шүүхийн шийдвэрийн төрөл
20.	График 20. ШССМХ-ийн Мэдээллийн төвөөс гаргасан мэдээ, мэдээлэл
21.	График 21. ШССМХ-ийн Мэдээллийн төвөөс гаргасан мэдээний төрөл
22.	График 22. "Монголын төр, эрх зүй" сэтгүүлд 2023 онд
23.	График 23. 2022 болон 2023 онд хийсэн гадаад улсын төлөөлөлтэй хийсэн уулзалтын тоон харьцуулалт


НЭГ. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Тус тайланд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн (цаашид ШССМХ гэх)-ийн 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 29-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын биелэлтийг тайлагнав.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 01 дугаар сарын 04-ны өдрийн “Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах” тухай 01 дүгээр захирамжийн дагуу тус хүрээлэн нь нийт 38 орон тоотой байхаар батлагдсан боловч тайлант хугацаанд дараах бүтэц, орон тоотой ажиллав.

- Захирал-1
- Сургалтын төв -5 /төвийн дарга, сургалт хариуцсан мэргэжилтэн 4/
- Судалгааны төв 17 /төвийн дарга, 16 судлаач/
- Мэдээллийн төв 4 /мэдээлэл, технологийн ажилтан 1, сэтгүүлч -2 хураангуй бэлтгэх ажилтан 1/
- Үйлчилгээний ажилтан 3 /захиргааны ажилтан, нягтлан, жолооч/ нийт 30 орон тоотой ажилласан байна.

Хүснэгт 1. ШССМХ-д 2023 онд ажилласан хүний нөөцийн мэдээлэл



Үүнээс гадна ШССМХ-ийн дэргэд 15 гишүүнтэй Сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хороо, 13 гишүүнтэй Монголын төр, эрх зүй сэтгүүлийн редакцын зөвлөл ажиллаж, 38 шүүгч-сургагч багш, 4 судлаач шүүгч нийт 42 шүүгч хамтран ажилласан байна.

Хүснэгт 2. 2023 онд хамтран ажилласан гишүүд, шүүгч нар



ХОЁР. ШҮҮХИЙН СУРГАЛТЫН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

Шүүхийн сургалтын төв нь Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасныг баримтлан “2022 оны шүүгчийн сургалтын тандан судалгаа”-ны үр дүнд үндэслэн Сургалтын хөтөлбөрийн хороогоор хэлэлцэн баталсан хөтөлбөрийн дагуу Шүүгчийн сургалтыг зохион байгуулж ажиллахаас гадна мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасан сургалтын хөтөлбөр боловсруулах чиг үүрэг бүхий Сургалтын хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, зохион байгуулалтыг хариуцан ажиллаа.

2.1. Сургалтын хөтөлбөрийн хороо

Тайлант хугацаанд Сургалтын хөтөлбөрийн хороо 6 удаа хуралдаж, 27 сургалтын хөтөлбөр хэлэлцсэн байна. Үүнээс;

- Батлагдсан – 22;
- Нэмэлт судалгаа хийж дахин хэлэлцэхээр буцаасан – 3;
- Шүүхийн ерөнхий зөвлөлд зөвшилцөхөөр хүргүүлсэн -1;
- Хэлэлцүүлэг хийхээр шийдвэрлэсэн – 1 хөтөлбөр тус тус байна.

Дээрх батлагдсан 22 хөтөлбөрийн 59 хувь нь заавал судлах, 41 хувь нь сонгон судлах сургалтын хөтөлбөр байсан.

Хүснэгт 3. Сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хорооны бүрэлдэхүүн

№	Бүрэлдэхүүн	Албан тушаал	Өөрийн нэр
1.	Хорооны дарга	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал	Д.Эрдэнэчимэг
2.	Хорооны гишүүд	Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн	Ч.Хосбаяр
3.		Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн	Г.Алтанчимэг
4.		Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн	Д.Мөнхтуяа
5.		Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	С.Өмирбек
6.		Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч	Ш.Оюунханд
7.		Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч	С.Мөнхжаргал
8.		Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	Н.Оюунтуяа
9.		Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	Б.Батаа
10.		Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	Т.Мөнх-Эрдэнэ
11.		Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн	Н.Мөнгөнцэцэг
12.		Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Эрдэнэбулган
13.		МУИС-ийн Хууль зүйн сургуулийн доктор, профессор	О.Мөнхсайхан
14.		МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор	С.Болормаа
15.		МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш	Б.Баасандорж

Хүснэгт 4. СХХ-ны хуралдааны мэдээлэл

Д/д	Хуралдаан	Зохион байгуулсан огноо	Зохион байгуулсан хэлбэр
1.	СХХ-ны I хуралдаан	2023.01.23	Танхим
2.	СХХ-ны II хуралдаан	2023.02.13	Танхим
3.	СХХ-ны III хуралдаан	2023.04.10	Танхим
4.	СХХ-ны IV хуралдаан	2023.06.05	Танхим
5.	СХХ-ны V хуралдаан	2023.10.16	Танхим
6.	СХХ-ны VI хуралдаан	2023.12.08	Танхим

Дээрх хуралдаанаар шийдвэрлэсэн асуудал:

- Сургалтын хөтөлбөрийн хорооны 2023 онд хуралдах хуваарь батлах;
- Сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулах;
- Хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (2 гишүүн өөр ажил албан тушаалд томилогдсон);
- Сургалтын 27 хөтөлбөрийг хэлэлцэж, 22 хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээр батлуулж, 1 хөтөлбөрийг батлуулахаар хүргүүлж, 3 хөтөлбөрийн хүрээнд судалгаа хийж, сайжруулан боловсруулж 2024 оны Хорооны хурлаар дахин хэлэлцэхээр болж, 1 хөтөлбөрийн хүрээнд сургалтын

хөтөлбөр боловсруулахаас өмнө хэлэлцүүлэг хийх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна.



Хорооны хуралдаанаар батлуулахаар дэмжсэн 22 хөтөлбөрийг Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Шүүхийн Ерөнхий Зөвлөлтэй зөвшилцөн баталсан. Үүнд:

- Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн захирамжаар 4 хөтөлбөр;
- Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн захирамжаар 11 хөтөлбөр;
- Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн захирамжаар 5 хөтөлбөр;
- Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн захирамжаар 2 хөтөлбөр;
- Сургалтын хөтөлбөрийн хорооны 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 6 дахь удаагийн хуралдаанаар 2023 оны шүүгчийн ёс зүй хичээлийн хөтөлбөрийг хэлэлцэн дэмжиж, УДШ-ийн Ерөнхий шүүгчээр батлуулахаар хүргүүлсэн байна.

Хүснэгт 5. Баталсан болон дахин хэлэлцэхээр хойшилсон сургалтын хөтөлбөр

БАТАЛСАН ХӨТӨЛБӨР		
Д/д	Сургалтын сэдэв	Багц цаг
Заавал судлах мэргэжлийн суурь сургалт (Үндсэн хуулийн эрх зүй, шүүгчийн ёс зүй)		
1.	Шүүх, маргаан таслах тусгай байгууллагын өмнө тэгш байх, шударгаар шүүлгэх эрх	0.25
2.	Чөлөөтэй, аюулгүй байх эрх	0.25
3.	Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах болон шүүгчид болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт	0.5
Заавал судлах мэргэшүүлэх сургалт (Салбар эрх зүй)		
4.	Арилжааны эрх зүй -1	1
5.	Арилжааны эрх зүй -2	0.5

6.	Худалдааны зуучлалын гэрээ	0.5
7.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарим зарчмууд	0.5
8.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд процессын хуулийг зөв хэрэглэх, нэгдмэл байдлыг хангах нь /Хүний эрхийн зарим зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь/	0.5
9.	Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа	0.5
10.	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх (цагаатгах) тогтоол бичих, боловсруулах аргачлал	0.5
11.	Захиргааны хэргийн шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг тогтооход анхаарах зарим асуудал, холбогдох хуулийг зөв хэрэглэх нь	1.5
12.	Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх үндэслэл	0.5
Заавал судлах бусад сургалт		
13.	Сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчийн сургалт	-
Сонгон судлах мэргэшүүлэх сургалт		
14.	Гэмт хэрэг зүйлчлэлийн онолын зарим асуудал	0.5
15.	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа	0.5
16.	Үүргийн гүйцэтгэлийг хангах арга: Батлагаа, Банкны баталгаа	0.5
17.	Санхүүгийн түрээсийн гэрээ	0.5
18.	Даатгалын эрх зүй	0.5
19.	Зөвшөөрлийн тухай хуулийн үзэл баримтлал, онцлог зохицуулалтууд	0.5
20.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн үзэл баримтлал, онцлог зохицуулалт	0.5
21.	МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн үзэл баримтлал, онолын зарим асуудал	0.5
22.	Эрүүгийн хэргийн үйл баримтад хууль зүйн дүгнэлт хийх аргачлал	0.5
БАТЛУУЛАХААР ХҮРГҮҮЛСЭН		
23.	Шүүгчийн ёс зүй, харилцаа, хандлага	0.5
ХОЙШИЛСОН ХӨТӨЛБӨР		
Заавал судлах мэргэжлийн суурь сургалт (Шүүгчийн ёс зүй)		
24.	Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 23 дахь заалт “Хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах”	0.5
Сонгон судлах мэргэшүүлэх сургалт		
25.	Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, эрх зүйн зохицуулалт	0.5
26.	Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн барьцаат зээлийн харилцаа	0.5
27.	Арбитрын ажиллагаан дахь шүүхийн дэмжлэг, оролцоо	0.5

График 1. 2022 болон 2023 он батлагдсан хөтөлбөрийн тоо харьцуулалт



График 2. Баталсан болон хойшилсон сургалтын хөтөлбөрийн хувь




График 3. Баталсан сургалтын хөтөлбөрийн ангилал



Хуралдаанаас гарсан шийдвэрийн талаар тухай бүр Мэдээллийн төвтэй хамтран ШССМХ-ийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэл хүргэн ажилласан.

2.2. Шүүгчийн сургалт

Шүүгчийн сургалтыг танхим, цахим болон хосолсон хэлбэрээр зохион байгуулж байгаа бөгөөд цахим сургалт нь вебинар, видео хичээлээр голчлон хүрч байна.

Шүүхийн сургалтын төвөөс 2023 онд танхимын сургалт 15, цахим хэлбэрээр 14, хосолсон хэлбэрээр 3, нийт 32 сургалт зохион байгуулсан байна.¹

Цахим сургалтын системд 69 контент байршуулснаас 50² нь шүүгчийн сургалтын видео хичээл, 6 нь сургалттай холбоотой дүрэм, журам, багц цагийн танилцуулга зэрэг мэдээллийн чанартай богино хэмжээний видео танилцуулга, 13 нь системийг ашиглахтай холбоотой зааварчилгаа байна.

Системд нийт 507 шүүгч бүртгэлтэй байгаагаас 375 шүүгч тайлант хугацаанд 2022 оны багц цаг олгох сургалтдаа бүрэн хамрагдаж батламжаа хүлээн авсан байна. Харин 2023 онд зохион байгуулахаар төлөвлөсөн 3 видео хичээлийн бичлэг бүрэн хийгдэж дуусаагүй байна.³

2.2.1. Танхимын сургалт

Сургалтын хөтөлбөрийн хорооноос баталсан Шүүхийн сургалтын нэгдсэн бодлогын дагуу заавал судлах мэргэшүүлэх сургалтыг танхимаар зохион байгуулахыг дэмжиж 2022 онд 11 сургалт, 2023 онд 15 сургалтыг танхимаар зохион байгуулсан байна.

График 4. Танхимаар зохион байгуулсан сургалт



Эдгээр сургалтаас заавал судлах мэргэшүүлэх эрүү, иргэн, захиргааны эрх зүйн чиглэлийн 2 багц цаг олгох сургалт тус бүрдээ 2-3 өдөр үргэлжилсэн бол бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан тухайлбал, Азийн сантай хамтран хэрэгжүүлсэн “Залуу шүүгчдийг чадавхжуулах менторшип хөтөлбөр” 6 сарын турш, “Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэх сургалт” 3 сарын хугацаанд буюу хамгийн урт үргэлжилсэн.

¹ 2022 онд сургалтын хөтөлбөр батлагдаж, 2023 онд зохион байгуулахаар төлөвлөсөн сургалтууд энд багтсан болно.

² Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн 2023 оны 2 дугаар сараас шүүгчийн сургалтад цахим систем нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн бөгөөд 2022 онд сургалтын хөтөлбөр нь батлагдаж 2023 онд зохион байгуулсан сургалтууд энд багтсан болно.

³ Сурлагч багш нар 12 дугаар сард багтаан бичлэгтээ орно гэж мэдэгдсэн байгаа.

Мөн тус сангийн дэмжлэгтэйгээр эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалтыг 21 аймаг, нийслэлийн 4 дүүрэгт бүсчлэн зохион байгуулсан юм.

Түүнчлэн “Хяналтын шатны шүүхийн шүүгчдийн сургалт”, “Сургагч багш бэлтгэх сургалт (иргэн)” болон “Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт” сэдэвт сургалтыг гадаад багшаар тус тус удирдуулан зохион байгууллаа.

Хүснэгт 6. Танхимаар зохион байгуулсан сургалт

Д/д	Сургалтын нэр	Сургалтын төрөл	Багц цаг	Сургалтын үргэлжилсэн хугацаа	Сургалтын ээлж
1.	Давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн мэргэшүүлэх сургалт	Заавал судлах	0.5	2 өдөр	1
2.	“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийг хохирогч төвтэй хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалт	Сонгон судлах	0.5	2 өдөр	1
3.	“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалт (25 удаагийн)	Сонгон судлах	0.5	50 өдөр	2
4.	Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэх сургалт (семинарын хичээл)	Заавал судлах	7	9 өдөр	1
5.	Давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн мэргэшүүлэх сургалт (ЗХДЗШШ)	Заавал судлах	0.5	Хагас өдөр	1
6.	Шинээр томилогдсон шүүгчийг шүүгчдийг чадавхжуулах менторшип хөтөлбөр	Сонгон судлах	1	6 сар	1
7.	Хяналтын шатны шүүхийн шүүгчдийн болон “Шүүгч сургагч багш бэлтгэх” сургалт (иргэн)	Заавал судлах	1.5	4 өдөр	1
8.	Хяналтын шатны шүүхийн шүүгчдийн “Цахим нотлох баримт” сэдэвт сургалт (эрүү)	Заавал судлах	0.5	Хагас өдөр	1
9.	Хяналтын шатны шүүхийн шүүгчдийн “ХБНГУ-ын улс төрийн нам татан буулгах үйл ажиллагаа, татан буулгах үндэслэл” сэдэвт сургалт (захиргаа)	Заавал судлах	0.5	Хагас өдөр	1

10.	“Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт” сэдэвт сургалт	Сонгон судлах	0.5	1 өдөр	1
11.	Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн заавал судлах мэргэшүүлэх сургалт (нийслэл)	Заавал судлах	2	4 өдөр	2
12.	Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн заавал судлах мэргэшүүлэх сургалт	Заавал судлах	2	2 өдөр	1
13.	Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн заавал судлах мэргэшүүлэх сургалт	Заавал судлах	2	9 өдөр	6
14.	“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн үзэл баримтлал, онолын зарим асуудал” сэдэвт сургалт	Сонгон судлах	0.5	Хагас өдөр	1
15.	“Эрүүгийн хэргийн үйл баримтад хууль зүйн дүгнэлт хийх аргачлал” сэдэвт сургалт	Сонгон судлах	0.5	Хагас өдөр	1

График 5. Танхимаар зохион байгуулсан сургалтын ангилал



Танхимаар зохион байгуулсан сургалт тус бүрийн мэдээллийг дор харуулбал,

1. Давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн сургалт

Тус сургалтын хөтөлбөрийг “Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал бичих, боловсруулах аргачлал” сэдвийн хүрээнд тус бүрд нь боловсруулан Хорооны хуралдаанаар дэмжин, Монгол Улсын дээд шүүхийн

Ерөнхий шүүгчийн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 72 тоот захирамжаар баталсан.

“Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал бичих, боловсруулах аргачлал” сэдэвт сургалтыг 2 ээлжээр зохион байгуулж, сургалтад 109 шүүгч хамрагдсан байна:

- 2023 оны 2 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд нийслэлийн болон орон нутгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүгчдэд зориулан Монгол Улсын дээд шүүхтэй хамтран танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, сургалтад 90 шүүгч танхимаар, 9 шүүгч цахимаар оролцсон.
- 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд танхимаар зохион байгуулж, сургалтад 10 шүүгч хамрагдсан.



2023 оны 2 дугаар сард зохион байгуулсан сургалтын үеэр Монгол Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ болон цаг үеийн шинжтэй асуудлаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч мэдээлэл хийсэн бол Улсын дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын Тэргүүн болон бусад шүүгчид хууль хэрэглээний нэгдмэл байдал, шүүхийн шийдвэрийн

хураангуй бэлтгэх зэрэг асуудлаар сургалтад хамрагдсан шүүгчидтэй харилцан ярилцаж, мэдээлэл солилцлоо.



Сургалтаар эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр боловсруулах аргачлалын үндэс, түүнийг заавал баримтлах учир шалтгаан, аргачлалыг баримтлаагүйгээс шүүхийн практикт үүссэн сөрөг үр дагавар болон давж заалдах шатны шүүхийн удиртгал, тодорхойлох, хянавал, тогтоох хэсэг бүрийн үүрэг, хэлбэр, агуулга, шүүхийн практикт тогтсон шийдвэр,

магадлалын хэв загвар, анхаарах асуудал, гадаад улсын шийдвэрээс авах сайн туршлага зэрэг сэдвийг хөндсөн болно.

2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийг хохирогч төвтэй хянан шийдвэрлэх ажиллагаа



Сургалтын хөтөлбөрийг боловсруулан Хорооны хуралдаанаар дэмжиж, Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 72 тоот захирамжаар баталсан.

Нийслэлийн эрүү, иргэний хэргийн давж заалдах болон дүүргийн эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхээс уг сургалтад хамрагдах хүсэлт ирүүлсэн 30 шүүгчийг 2023 оны 1

дүгээр сарын 30-31-ний өдрүүдэд танхимаар хамруулсан бол сургалтыг сонирхож буй бусад шүүхийн шүүгчдэд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)-ийн дэмжлэгтэйгээр сургалтын видео хичээл бэлтгэж, шүүгчийн сургалтын цахим системд байршуулсан.



Сургалтыг УДШ-ийн шүүгч Б.Батцэрэн, БЗД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Одонтуул, Жэндэрийн үндэсний шинжээч Х.Баавгай, Сүхбаатар дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Л.Бадамцэцэг, ЦЕГ-ын Гэрч, хохирогчийн хамгаалах хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Д.Энх-Амгалан нар удирдан явууллаа.

Уг сургалт нь сонгон судлах 0.5 багц цагийн сургалт бөгөөд цахим системд байршуулсан сургалтыг 173 шүүгч үзэж судалсан байна.

3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хянан шийдвэрлэх ажиллагаа

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 72 тоот захирамжаар баталсан. Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд хүүхдэд ээлтэй, хохирогч төвтэй, сэтгэцийн гэмтэл цочролд суурилсан сургалтын гарын авлагыг олон улсын болон үндэсний зөвлөхүүдтэй хамтран боловсруулж, 2022 оны 9 дүгээр сарын 19-23-ны хооронд "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан



шийдвэрлэх ажиллагаа" сэдэвт сургалтыг удирдан явуулах үндэсний мастер сургагч-багш бэлтгэх 5 хоногийн сургалтыг зохион байгуулсан.

Энэхүү сургагч багш бэлтгэх сургалтад ШССМХ-ийн 4 шүүгч багш хамрагдан бэлтгэгдсэн бөгөөд сургалтыг Азийн сантай хамтран 2023 оны 3-6 сар, 9-11 сарын хугацаанд 21 аймаг, нийслэлийн 5 дүүргийн хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг бүсчлэн хамруулж танхимаар зохион байгууллаа.



Уг сургалт нь сонгон судлах 0.5 багц цагийн сургалт бөгөөд эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 120 шүүгч хамрагдах хүсэлт ирүүлснээс 107 шүүгч сургалтдаа бүрэн хамрагдсан байна.

4. Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэн дадлагажуулах сургалт

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 24 тоот захирамжаар баталсан.



Хүрээлэн Азийн сантай хамтран “Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэн дадлагажуулах” сургалтын 24 төрлийн хичээлийг видео хэлбэрээр 2022 оны 6 сараас хойш бэлтгэн Шүүгчийн сургалтын цахим системд 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс 2 сарын

хугацаатай байршуулсан. Сургалтын цахим системд 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс хойш анхан шатны шүүхэд шинээр томилогдсон эрүүгийн хэргийн - 18, иргэний хэргийн - 17, захиргааны хэргийн – 8, нийт 43 шүүгчийг бүртгэж 24 сургалтыг салбар эрх зүйгээр ангилан хуваарилсан.

Шүүгчид цахим сургалтаа үзэж дууссаны дараа 2023 оны 5 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд семинарын хичээлийг Улаанбаатар хотод танхимаар



зохион байгуулав. Тахимын сургалтад 41 шүүгч хамрагдаж батламжаа гардан авсан.

Түүнчлэн дээрх сургалтын дараагаар анхан шатны шүүхэд шинээр томилогдсон 14 шүүгчийг цахим системд бүртгэн, салбар эрх зүй тус бүрээр хичээлийг хуваарилан судлуулж байна.

5. Шинээр томилогдсон шүүгчийг чадавхжуулах менторшип хөтөлбөр



Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 24 тоот захирамжаар “Шинээр томилогдсон шүүгчийг чадавхжуулах менторшип” хөтөлбөрийг баталсан.

Хүрээлэн Азийн сантай хамтран тус хөтөлбөрийг 2022 оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдөр хүртэл 6 сарын хугацаанд хэрэгжүүлсэн.

Хөтөлбөрт оролцох хүсэлт

ирүүлсэн шүүгчдээс шалгуурыг хангасан 11 Ментор (эрүү – 6, иргэн – 4, захиргаа – 1), 22 Менти (эрүү – 6, иргэн – 13, захиргаа – 3) нийт 33 шүүгч энэ удаагийн хөтөлбөр хамрагдсан бөгөөд Хяналтын шатны шүүхээс – 1, давж заалдах шатны шүүхээс – 2, анхан шатны шүүхээс – 8 шүүгч Ментор шүүгчээр оролцсон.

Уг хөтөлбөрт сонгон судлах сургалтын 1 багц цагийг тооцохоор заасны дагуу хөтөлбөрт хамрагдсан 33 шүүгчид зохиох багц цагийг олгосон.



6. Хяналтын шатны шүүхийн шүүгчдийн болон “Шүүгч сургагч багш бэлтгэх” сургалт (иргэн)

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн нь Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн “Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, чадавхыг сайжруулах” төсөлтэй хамтран “Арилжааны эрх зүй” сэдвийн хүрээнд Хяналтын шатны шүүхийн шүүгчид болон шүүгч-сургагч багш (иргэн) бэлтгэх сургалтыг 2023 оны 6 дугаар сарын 12-15-ны өдөр танхимаар зохион байгуулсан.

Сургалтыг ХБНГУ-ын Бавари мужийн Пассау хотын Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, ноён Рүдольф Хэлмхагэн удирдан явуулсан бөгөөд сургалтад иргэний хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны нийт 15 шүүгч хамрагдсан бөгөөд энэхүү сургалтад хамрагдсан шүүгч-сургагч багш нар Сургалтын хөтөлбөрийн хорооны баталсан иргэний хэргийн шүүхийн шүүгчдийн



2023 оны сургалтын хөтөлбөрийн дагуу “Арилжааны эрх зүй 1, 2”, “Даатгалын эрх зүй”, “Үүргийн гүйцэтгэлийг хангах арга: Баталгаа, банкны баталгаа” сэдэвт сургалтыг тус тус удирдан явуулсан юм.

Уг сургалт нь 4 өдрийн 1.5 багц цагийн сургалт бөгөөд сургалтад хамрагдсан шүүгчдэд зохиох багц цагийг олгосон.

7. Хяналтын шатны шүүхийн шүүгчдийн мэргэшүүлэх сургалт

Шүүгчийн сургалтын 2022-2024 оны нэгдсэн бодлогын үндсэн зорилгын хүрээнд “Сургалтын үйл ажиллагаа, агуулга шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг ямагт сахих, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад чиглэнэ.”, мөн “Сургалтын хэрэгцээ, шаардлагыг шүүх, шүүгч болон шүүхээр үйлчлүүлэгчдээс тандан судлах тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлнэ.” гэж

тус тус заасны дагуу Улсын дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүгчдээс авсан сургалтын хэрэгцээ, шаардлагын тандан судалгаанд үндэслэн хяналтын шатны шүүхийн шүүгчдэд зориулан “Цахим нотлох баримт”, “ХБНГУ-ын улс төрийн нам татан буулгах үйл ажиллагаа, татан буулгах үндэслэл” сэдэвт сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 12-13-ны өдөр Ханнс-Зайдел сангийн Эрх зүйн боловсрол төслийн дэмжлэгтэйгээр танхимаар зохион байгуулсан.





Энэхүү сургалтыг Вюрцбургийн их сургуулийн эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүй, эрх зүйн онол, мэдээллийн эрх зүй, эрх зүйн информатикийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор Эрик Хилгендорф “Цахим нотлох баримт”, Ханнс-Зайделийн сангийн Ерөнхий нарийн бичгийн дарга Оливер Иёрг “ХБНГУ-ын улс төрийн нам татан буулгах үйл ажиллагаа, татан буулгах үндэслэл” сэдвийн хүрээнд тус тус удирдан

явууллаа.

2023 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн сургалтад Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимын 13 шүүгч, 9 дүгээр сарын 13-ны өдрийн сургалтад Улсын дээд шүүхийн захиргаа, иргэний хэргийн танхимын нийт 9 шүүгч тус тус хамрагдлаа.

8. Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт



Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран “Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт” сэдэвт сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр 2 дахь жилдээ шүүгчдэд зориулан зохион байгуулав.

Сургалт “Оюуны өмчийн болон бусад цахим гэмт хэргийн нотолгоог шүүхэд гаргах”, “Оюуны өмчийн хуулиудын хөгжил дэвшил”, “Оюуны

өмчийн хэргийн үнэлгээ, хохирлыг тооцох”, “Оюуны өмчийн хэргийн хохирогчид үзүүлэх нөлөө” зэрэг сэдвийн хүрээнд танхимаар зохион байгуулагдсан.

Уг сургалт нь сонгон судлах 0.5 багц цагийн сургалт бөгөөд оюуны өмчийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэж байсан болон уг сэдвээр судалгаа хийж байсан эрүү, иргэн, захиргааны хэргийн бүх шатны шүүхээс нийт 31 шүүгч тус сургалтад хамрагдсан.



9. Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн заавал судлах сургалт



Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарим зарчмууд”, 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 45 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтаар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд процессын хуулийг зөв хэрэглэх, нэгдмэл байдлыг хангах нь /Хүний эрхийн зарим зөрчлөөс

урьдчилан сэргийлэх нь”, 4 дүгээр хавсралтаар “Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа”, 5 дугаар хавсралтаар “Анхан шатны шүүхийн шийтгэх (цагаатгах) тогтоол бичих, боловсруулах аргачлал” мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг тус тус баталсан.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах болон дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 2 багц цаг хангах (заавал судлах) сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд 2 ээлжид хуваарилан I ээлжийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн сургалтын танхимд, II дугаар ээлжийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд тус тус зохион байгуулсан.



Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах болон дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 105 шүүгчээс 88 шүүгч уг сургалтад танхимаар хамрагдсан. Сургалтад хамрагдаагүй 17 шүүгчийн 8 шүүгч нь хүндэтгэн үзэх шалтгаан (өвчтэй, орон нутгийн болон гадаад томилолттой)-тай байсан.

10. Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн заавал судлах мэргэшүүлэх сургалт



Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 05 дугаар сарын 04- ний өдрийн 26 дугаар захирамжийн 4 дүгээр хавсралтаар “Захиргааны хэргийн шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг тогтооход анхаарах зарим асуудал, холбогдох хуулийг зөв хэрэглэх нь” мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг баталсан.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн ХБНГУ-ын Ханнс- Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран Захиргааны хэргийн давж заалдах болон анхан шатны шүүхийн шүүгчдийн заавал судлах 2 багц цагийн сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 2, 3- ны өдрүүдэд танхимаар зохион байгуулсан.

Сургалтын үеэр Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь суурин Төлөөлөгчийн газрын тэргүүн ноён Феликс Гленк мэндчилгээ дэвшүүлж, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа сургалтад хамрагдсан нийт шүүгчидтэй “Захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн хууль хэрэглээний нэгдмэл байдал” сэдвээр нээлттэй ярилцсан юм.



Захиргааны хэргийн давж заалдах болон анхан шатны шүүхийн нийт 82 шүүгч сургалтад хамрагдахаас 67 шүүгч танхимаар, 7 шүүгч цахимаар оролцсон. Сургалтад хамрагдаагүй 8 шүүгч нь хүндэтгэн үзэх шалтгаан (өвчтэй, орон нутгийн болон гадаад томилолттой)-тай байсан.

11. Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн заавал судлах мэргэшүүлэх сургалт



Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 13 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар “Арилжааны эрх зүй-1”, 2 дугаар хавсралтаар “Арилжааны эрх зүй-2”, 3 дугаар хавсралтаар “Даатгалын эрх зүй” “Үүргийн гүйцэтгэлийг хангах арга: Баталгаа, банкны баталгаа” 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар захирамжийн 7 дугаар хавсралтаар “Худалдааны зуучлалын гэрээ”, 8 дугаар

хавсралтаар “Санхүүгийн түрээсийн гэрээ” мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг тус тус баталсан.

Энэхүү хөтөлбөрийн дагуу сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 23-25-ны өдөр, 10 дугаар сарын 30-ны өдрөөс 11 дүгээр сарын 04-ний өдөр хүртэл хугацаанд нийслэл, орон нутгийн иргэний хэргийн давж заалдах болон анхан шатны шүүхийн шүүгчдэд зориулан 6 ээлж (1 ээлж 3 өдрийн хугацаанд)-ээр, танхимаар зохион байгууллаа.



Сургалтын үеэр Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг УДШ-ээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарласан тайлбар болон хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах талаар мэдээллийг шүүгчдэд хүргэн, харилцан хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Сургалтад нийслэл, орон нутгийн иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны 240 шүүгч хамрагдсан.

Тус сургалтын хүрээнд сургагч багш бэлтгэх сургалт болон энэхүү сургалтыг удирдан явуулсан 12 багшийн урамшуулал, сургалтын гарын авлагыг бэлтгэн хэвлүүлэхэд Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) санхүүгийн дэмжлэг үзүүлсэн бол Шүүхийн ерөнхий зөвлөл 1 ээлжийн сургалт зохион байгуулах сургалтын танхимаар хангахад туслалцаа үзүүлэн хамтран ажилласан.

12. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн үзэл баримтлал, онолын зарим асуудал



Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 82 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн үзэл баримтлал, онцлог зохицуулалт” сонгон судлах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг баталсан.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн 2023 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг хамруулан Улаанбаатар хотод танхимаар зохион байгуулсан.

Сургалтыг дээрх хуулийг шинэчлэх болсон шалтгаан, мөн хуулийн үзэл баримтлал, шинэлэг зохицуулалт зэрэг агуулгын хүрээнд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн ахлах багш Д.Ганзориг удирдан явуулсан бөгөөд сургалтад 40 шүүгч хамрагдсан.



13. Эрүүгийн хэргийн үйл баримтад хууль зүйн дүгнэлт хийх аргачлал



Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 82 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар “Эрүүгийн хэргийн үйл баримтад хууль зүйн дүгнэлт хийх аргачлал” сонгон судлах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг баталсан.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Эрүүгийн

хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг хамруулан Улаанбаатар хотод танхимаар зохион байгууллаа.


Сургалтыг “Эрүүгийн хуулийн хэм хэмжээ бүтээх болон задрах арга зүй”, “Эрүүгийн хуулийн тодорхой хэм хэмжээний бүтэц”, “Эрүүгийн хуулийн тодорхой хэм хэмжээг хэргийн үйл баримттай харьцуулах замаар хууль зүйн дүгнэлт бичих аргачлал” зэрэг дэд сэдвийн хүрээнд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор Т.Золбоо удирдан явуулсан бөгөөд сургалтад 48 шүүгч хамрагдсан.



2.3. Цахим сургалт

Тайлангийн энэ хэсэгт 2022 онд цахимаар зохион байгуулсан сургалт болон шүүгчийн сургалтын цахим систем ашиглалтад орсноос хойших буюу 2023 оны 2 дугаар сараас хойш тус системд байршуулсан сургалтын талаарх мэдээллийг тусгав.

График 6. 2022, 2023 оны цахим сургалт



Шүүгчийн сургалтын цахим платформ <https://training.jtrii.mn/> -ийг 2023 оны 2 дугаар сараас шүүгчдийн сургалтын хэрэглээнд нэвтрүүлсэн. Уг платформд нийт 507 шүүгчийг бүртгэж, 69 сургалтын контентыг (2022 оны нөхөн судалж багц цаг хангах болон 2023 оны багц олгох сургалт) цахимаар үзэхээр байршуулсан.

Цахим системийг хэрэглээнд нэвтрүүлснээс хойш шүүгчдэд системд нэвтрэх нэр, нууц үг болон бусад зааварчилгааг цахим шуудангаар мөн харьяалах шүүхийн Ерөнхий шүүгч, Тамгын газраар дамжуулан мэдээлж ажилласнаас гадна цахим

системийг хэрхэн ашиглах талаар богино хэмжээний 13 танилцуулгыг видео хэлбэрээр бэлтгэн байршуулж, шүүгч бүртэй утсаар холбогдон зааварчилгаа өгч цахим системээр мэдэгдэл хүргүүлэн ажиллав. Системд нэвтэрч буй шүүгчдийн сургалтын идэвх 90 хувьтай байна.

Мөн шүүгчдийн гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Oxford-ийн англи хэлний хөтөлбөр”-ийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн, шүүгчдэд сургалтын зар мэдээллийг цахим шуудан болон цахим системээр дамжуулан хүргэж, суралцах хүсэлтийг хүлээн авсан. Хүсэлт ирүүлсэн шүүгчдийг бүртгэж, түвшин тогтоох шалгалт авсан бөгөөд шалгалтын дүнд үндэслэн 3 анги болгон хуваарилалт хийсэн. Тус сургалтыг 2024 оны 1 дүгээр сараас эхлэн 3 сарын хугацаанд цахим хэлбэрээр зохион байгуулахаар ажиллаж байна.

Хүснэгт 7. Цахим системд байршуулсан контент

Д/д	Сургалтын ангилал	Хичээлийн нэр	Байршсан сургалтын тоо
1.	Үндсэн хуулийн эрх зүй	Үндсэн хуулийн эрх зүй-1 2022 он	4
		Үндсэн хуулийн эрх зүй-2 2022 он	
		Чөлөөтэй, аюулгүй байх эрх-2023 он	
		Шүүх, маргаан таслах байгууллагын өмнө тэгш байх, шударгаар шүүлгэх эрх	
2.	Шүүгчийн ёс зүй	Шүүгчийн ёс зүй - 2022 он	1
3.	Эрүүгийн эрх зүй	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хянан шийдвэрлэх нь	8
		Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа	
		Шүүх эмнэлгийн шинжилгээ	
		Цахим гэмт хэрэг: кибер аюулгүй байдал ба цахим орчин дахь гэмт явдал (Нөхөн сургалт-2022)	
		Гэмт хэрэг зүйлчлэлийн онолын зарим асуудал ба тодорхой төрлийн гэмт хэрэг	
		Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд процессын хуулийг зөв хэрэглэх, нэгдмэл байдлыг хангах нь /Хүний эрхийн зарим зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь/	
		Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх нь	
		“Эрүүгийн хэргийн үйл баримтад хууль зүйн дүгнэлт хийх аргачлал” сэдэвт сургалт	
4.	Иргэний эрх зүй	Гэм хорын эрх зүй	2
		Төлбөрийн чадваргүйдлийн эрх зүй	
5.	Захиргааны эрх зүй	Өрсөлдөөний эрх зүй	3
		Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	

		Зөвшөөрлийн тухай хуулийн үзэл баримтлал, онцлог зохицуулалтууд	
6.	Салбар дундын мэдлэг олгох	Шүүхийн хэл шинжлэл ба монгол хэлний найруулга зүй Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийг хохирогч төвтэй хянан шийдвэрлэх ажиллагаа Цахим гэмт хэрэг: кибер аюулгүй байдал ба цахим орчин дахь гэмт явдал Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмыг хэрэглэх талаар Шүүхийн шийдвэрийн хураангуй тойм бэлтгэх аргачлал Шүүгч түүний гэр бүлийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах болон шүүгчид болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	7
7.	Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийн сургалт	Шүүхийн эрх зүй Шүүгчийн ёс зүй Шүүгчийн хараат бус байдал ба хариуцлага Шүүгчийн нийгмийн мэдрэмж Шүүхийн практик судлал Иргэний хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй Эрүүгийн хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй Захиргааны хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй Нотлох баримт, түүнийг үнэлэх /Иргэн/ Нотлох баримт, түүнийг үнэлэх /Эрүү/ Нотлох баримт, түүнийг үнэлэх /Захиргаа/ Шүүхийн шийдвэр гаргах /Иргэн/ Шүүхийн шийдвэр гаргах /Эрүү/ Шүүхийн шийдвэр гаргах /Захиргаа/ Шүүхийн сэтгэл зүй, шүүгчийн харилцаа хандлага Хэргийн хөдөлгөөний удирдлага /Эрүү/ Хэргийн хөдөлгөөний удирдлага /Захиргаа/ Хэргийн хөдөлгөөний удирдлага /Иргэн/ Шүүгчийн ажлын зохион байгуулалт Хялбаршуулсан болон шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх Мэтгэлцэх зарчим Шүүх хуралдаанд бэлтгэх, хуралдаан удирдах /Эрүү/ Шүүх хуралдаанд бэлтгэх, хуралдаан удирдах /Иргэн/	25

		Шүүх хуралдаанд бэлтгэх, хуралдаан удирдах /Захиргаа/	
		Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх нь	
8.	Бусад	Батламж - 2022 он	6
		Шүүхийн цахим сургалтын системийн танилцуулга	
		Шүүгчийн сургалтын багц цагийн танилцуулга	
		Шүүгчийн сургалтын хөтөлбөр батлах үе шат	
		Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд /Ажилласан жил тогтоох/	
		Шүүгчийн сургалтын үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журам	
9.	Системийн сургалт	Хэрэглэгчийн профайл	13
		Цахим сургалт	
		Цахим сургалтын карт	
		Танхимын сургалт	
		Сургалтын хуанли	
		Санал асуулга	
		Цахим номын сан	
		Шалгалт цэс	
		Зарлал мэдээлэлтэй танилцах	
		Вебинар сургалт	
Нийт			69

2.3.1. 2022 оны багц цаг олгох сургалт

Хүснэгт 8. Цахим системд байршуулсан видео хичээл-2022 он

Д/д	Сургалтын нэр	Сургалтын ангилал	Багц цаг
1.	Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан үндсэн эрхийг тайлбарлах арга зүй	Заавал судлах	0.5
2.	Тэгш эрх ялгаварлан гадуурхалтыг хориглох зарчим	Заавал судлах	0.5
3.	Шүүгчийн ёс зүй	Заавал судлах	0.5
4.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа	Сонгон судлах	1
5.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хянан шийдвэрлэх нь	Сонгон судлах	0.5
6.	Шүүх эмнэлгийн шинжилгээ	Сонгон судлах	0.5
7.	Цахим гэмт хэрэг: кибер аюулгүй байдал ба цахим орчин дахь гэмт явдал	Заавал судлах	0.5
8.	Гэм хорын эрх зүй	Сонгон судлах	1
9.	Төлбөрийн чадваргүйдлийн эрх зүй	Сонгон судлах	1


10.	Өрсөлдөөний эрх зүй	Сонгон судлах	0.5
11.	Шүүхийн хэл шинжлэл ба монгол хэлний найруулга зүй	Сонгон судлах	0.5

График 7. Цахим сургалтын ангилал



1. Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан үндсэн эрхийг тайлбарлах арга зүй

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙ-1 2022 ОН



Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 39 тоот захирамжаар баталсан. Сургалтыг 2022 онд нийслэл дэх шүүхийн шүүгчдэд танхимаар зохион байгуулсан бөгөөд орон нутгийн шүүхийн шүүгчдэд цахим хэлбэрээр хүргэхээр шийдвэрлэсэн юм.

Тус сургалтыг Үндсэн хуулийн цэцийн гишүүн, хууль зүйн доктор


О.Мөнхсайхан удирдан, 2 цаг 45 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 236 шүүгч хамрагдсан байна.

2. Тэгш эрх ялгаварлан гадуурхалтыг хориглох зарчим


Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 39 тоот захирамжаар баталсан. Сургалтыг 2022 онд нийслэл дэх шүүхийн шүүгчдэд танхимаар зохион байгуулсан бөгөөд орон нутгийн шүүхийн шүүгчдэд цахим хэлбэрээр хүргэхээр шийдвэрлэсэн юм.

ШҮҮГИЙН СУРГАЛТ

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙ-2 2022 ОН



Тус сургалтыг Хүний эрхийн үндэсний комиссын дарга, хууль зүйн доктор Д.Сүнжид удирдан, 1 цаг 30 минутын видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 245 шүүгч хамрагдсан байна.



3. Шүүгчийн ёс зүй-2022 он

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 72 тоот захирамжаар баталсан. Сургалтыг 2022 онд нийт шүүгчид вебинар хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сургалтад хамрагдаагүй шүүгчдэд зориулан цахим хэлбэрээр бэлтгэн хүргэсэн.

Тус сургалтыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч А.Сарангэрэл удирдан, 2 цагийн 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 12 шүүгч хамрагдсан байна.

4. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хянан шийдвэрлэх нь

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 72 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Д.Очмандах, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Одонтуул, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Оч нар тус тус удирдан, 3 цагийн 5 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 123 шүүгч хамрагдсан байна.



5. Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа



хүрээлэнгийн тусгай шинжилгээний газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Дамчин, ХЭҮК-ийн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Б.Энхболд, Цагдаагийн Ерөнхий газрын хар тамхитай тэмцэх газрын ахлах, цагдаагийн ахмад, М.Зоригтбаатар, Дотоод хэргийн их сургуулийн дэд профессор С.Гантулга, Гаалийн ерөнхий газрын гаалийн зөрчилтэй тэмцэх хэрэг, бүртгэх газрын хар тамхины хяналтын албаны гаалийн улсын байцаагч Г.Ганзориг, Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн нар тус тус удирдан, 3 цаг 25 минутын 7 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 124 шүүгч хамрагдсан байна.

6. Шүүх эмнэлгийн шинжилгээ

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 51 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг АШУУИС-ийн эмгэг судлал, шүүх эмнэлгийн тэнхимийн багш, АУ-ын доктор, дэд профессор М.Цэрэнбат удирдан, 3 цагийн 4 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 144 шүүгч хамрагдсан байна.



Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 24 тоот захирамжаар баталсан. Энэхүү сургалтыг 2022 онд 30 шүүгчийн хамруулан танхимаар 1 удаа зохион байгуулсан бөгөөд эдгээр шүүгчээс бусад шүүгчид цахим хэлбэрээр хүргэхээр шийдвэрлэсэн юм. Тус сургалтыг Шүүхийн шинжилгээний үндэсний

7. Цахим гэмт хэрэг: кибер аюулгүй байдал ба цахим орчин дахь гэмт явдал (Нөхөн сургалт-2022)

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 8 дугаар сарын 19-ны өдрийн 51 тоот захирамжаар баталсан.

Энэхүү сургалтыг 2022 онд эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Хосолсон сургалтын үеэр техникийн хүндрэл гарсантай холбоотойгоор сургалтыг цахим хэлбэрээр дахин бэлтгэж шүүгчдэд хүргэхээр шийдвэрлэсний дагуу сургалтыг Улсын дээд шүүхийн кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Энхтөр, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Батаа нар тус тус удирдан, 2 цагийн 4 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 144 шүүгч хамрагдсан байна.

Түүнчлэн уг сургалтыг 2022 онд эрүүгийн хэргийн шүүхийн шүүгчдэд заавал судлах сургалтаар хуваарилж байсан бол 2023 онд бусад шүүгчид сонгон судлах боломжтойгоор байршуулсан. Сургалтад 73 шүүгч хамрагдсан байна.



СЭДЭВ 1. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН СУУРЬ ЗАРЧМУУД, ИРГЭНИЙ ХУУЛЬ ТАЙЛБАРЛАХ АРГА ЗҮЙ

Сэдвийн зорилго: Иргэний эрх зүйн суурь болон тусгай зарчмуудын хүрээнд Иргэний хуулийн зохицуулалтыг зөв тайлбарлаж хэрэглэх чадварыг сайжруулах.

- Зарчмуудын хоорондын уялдаа холбоо, хуулийн заалт
- Бүх маргаан-бүрэн бүтэн, тодорхой, хангалттай шийдэл
- Ирээдүйд үүсэх тохиолдол
- Шүүгч маргааны үйл баримт-дотоод итгэл
- Хууль тайлбарлах аргыг зөв сонгож хэрэглэх

8. Гэм хорын эрх зүй

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 6 дугаар сарын 17-ний өдрийн 39 тоот захирамжаар баталсан.


Тус сургалтыг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны Ерөнхий шүүгч

Ж.Оюунтунгалаг удирдан, 2 цагийн 3 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 165 шүүгч хамрагдсан байна.

Төлбөрийн чадваргүйдлийн эрх зүй

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 6 дугаар сарын 17-ний өдрийн 39 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг Улсын дээд шүүхийн шүүгч Н.Баярмаа удирдан 2 цаг 40 минутын 5 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 157 шүүгч хамрагдсан байна.



Өрсөлдөөний эрх зүй

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

- Leniency Program:
- Энэ нь картельд оролцогчоос өөрийн үйлдлийг хүлээн зөвшөөрч холбогдох байгууллагад мэдээлсэн хүсэлт гаргах явдал. Энэ хөтөлбөр нь 1996 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд картельд оролцсон компаниудыг өөрсдийн хууль бус үйлдлийг сайн дураараа мэдээлж, шаардлагатай нотлох баримтыг гаргаж өгөх боломжийг олгодог бөгөөд ингэснээр торгууль ногдуулахгүй байх эсхүл торгуулийн хэмжээг багасгах боломжийг бүрдүүлдэг юм. Түүнчлэн уг хөтөлбөр нь нууц картель болон зөрчлийн тухай мэдээллийг авах боломжийг Комисст бүрдүүлж өгдөг байна.

9. Өрсөлдөөний эрх зүй

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 6 дугаар сарын 17-ний өдрийн 39 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Мөнх-Эрдэнэ удирдан 2 цаг 20 минутын 4 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 44 шүүгч хамрагдсан байна.

10. Шүүхийн хэл шинжлэл ба монгол хэлний найруулга зүй

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 6 дугаар сарын 17-ний өдрийн 39 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнгийн хэрэглээний хэл шинжлэлийн салбарын эрхлэгч, ЭШТА, доктор Н.Мөнхцэцэг удирдан 1 цаг 10 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 184 шүүгч хамрагдсан байна.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

3.1.3 Эрдэм шинжилгээний найруулга

Шинжлэх ухааны ололтыг нийтэд цогцтой, оновчтой, хүргэх зорилгоор туурвисан нэвтрэхий тайлбар толь, лавлах, гарын авлага, эмхэтгэл, товхимол зэргийн хэлнйг эрдэм шинжилгээний найруулга гэнэ.


- Эрдэм шинжилгээний найруулгын онцлог
 - Аливаа тогтолцоо, баримт, судалгааг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, мэдээлэх
 - Албан ёсны шинж байдтай
 - Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, шүүмж, мэдээлэл, сурах бичиг, таних сэдэвт бүтээл зэрэг багтдаг.
 - Үгсийн сангийн хувьд мэргэжлийн үг хэллэг, нэр томьёо их хэрэглэдэг.
 - Учир шалтгааны нарийн дарвалалтай байдаг.
 - Нөлөөлөх буюу итгүүлэн батлах тал нь их байдаг.
 - Утга санаа тодорхой, нэгтгэн дүгнэсэн байдаг.
 - Хэлний хэрэгсэл нь шинжлэх ухааны зохиолын мэдээлэх ба нөлөөлөх гэсэн зорилгын хэрэгжүүлэхэд чиглэсэн байдаг.

2.3.2. 2023 оны багц цаг олгох сургалт

Хүснэгт 9. Цахим системд байршуулсан видео хичээл болон вебинар сургалт-2023 он



Д/д	Сургалтын нэр	Сургалтын төрөл	Багц цаг
1.	Сургагч багш бэлтгэх заах арга зүйн сургалт	Заавал судлах	-
2.	Цахим гэмт хэрэг: кибер аюулгүй байдал ба цахим орчин дахь гэмт явдал	Сонгон судлах	0.25
3.	Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийн сургалт (лекц)	Заавал судлах	17
4.	Шүүхийн шийдвэрийн хураангуй тойм бэлтгэх аргачлал, олон нийтэд мэдээлэх журам	Сонгон судлах	-
5.	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийг хохирогч төвтэй хянан шийдвэрлэх ажиллагаа	Сонгон судлах	0.5
6.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн үзэл баримтлал, шинэлэг зохицуулалт	Сонгон судлах	0.5
7.	Зөвшөөрлийн тухай хуулийн үзэл баримтлал, онцлог зохицуулалтууд	Сонгон судлах	0.5
8.	Гэмт хэрэг зүйлчлэлийн онолын зарим асуудал ба тодорхой төрлийн гэмт хэрэг	Сонгон судлах	0.5
9.	Шүүхэд маргаан таслах байгууллагын өмнө тэгш байх, шударгаар шүүлгэх эрх	Заавал судлах	0.25
10.	Чөлөөтэй аюулгүй байх эрх	Заавал судлах	0.25
11.	“Мэтгэлцэх ур чадвар” контент	Сонгон судлах	0.5
12.	Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах болон шүүгчид болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох	Заавал судлах	0.5
13.	“Сургахуйн заах арга зүй” сэдэвт шүүгч сургагч-багш бэлтгэх сургалт	Заавал судлах	0.5
14.	“Эрүүгийн хэргийн үйл баримтад хууль зүйн дүгнэлт хийх аргачлал” сэдэвт сургалт	Сонгон судлах	0.5

График 8. Цахим сургалтын ангилал




1. Сургагч багшийн заах арга зүй

Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-аас бэлтгэсэн “Заах арга зүй” цахим сургалтад ШССМХ-ийн шүүгч сургагч багш болон ментор шүүгчдийг 2023 оны 1 дүгээр сард хамруулав. Сургалтыг нээснээс хойш 60 хоногийн хугацаанд хичээлүүдийг бүрэн үзэж судалсан байх шаардлагатай бөгөөд уг хугацаанд сургалтад бүртгүүлсэн 37 шүүгчээс 15 нь хичээлээ бүрэн судалж “Сургагч багшийн батламж” авсан байна.



2. Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэх сургалт

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 24 тоот захирамжаар баталсан. Сургалт нь



шинээр томилогдсон шүүгчдэд зайлшгүй шаардлагатай суурь мэдлэг болон материаллаг, процессын эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, шүүгчийн мэргэжлийн онцлог, ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилготой 24 видео хичээлээс бүрдсэн.


Сургалтыг 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс хойш анхан шатны шүүхэд шинээр томилогдсон эрүүгийн хэргийн - 18, иргэний хэргийн - 17, захиргааны хэргийн - 8 нийт 43 шүүгчийг хамруулан 3 сарын хугацаанд зохион байгуулсан. Ингэхдээ эхний 2 сард Шүүгчийн сургалтын цахим системд байршуулсан видео хичээлийг бүрэн үзэж судлах, дараагийн 1 сарын хугацаанд семинарын хичээлд танхимаар хамрагдах байдлаар зохион байгууллаа.






Сургалтад анхан шатны шүүхэд шинээр томилогдсон 43 шүүгчийг бүртгэж, 24 сургалтыг салбар эрх зүйгээр ангилан хуваарилж судлуулсан бөгөөд 2023 оны 5 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд цахимаар судалсан хичээлийг бататгах зорилгоор семинарын хичээлийг танхимаар зохион байгуулж 41 шүүгч хамрагдан батламж гардан авсан.

Мөн энэхүү сургалтын хүрээнд Азийн сангийн дэмжлэгтэйгээр сургалтын гарын авлагыг хэвлүүлэн, шүүгч бүрд тараахаас гадна цахим хэлбэрээр сургалтын системээс үзэх боломжтойгоор байршуулаад байна.



Түүнчлэн дээрх сургалтын дараагаар анхан шатны шүүхэд шинээр томилогдсон 14 шүүгчийг цахим системд бүртгэн, салбар эрх зүй тус бүрээр хичээлийг хуваарилан судлуулж байна.

Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийн сургалтын хүрээнд бэлтгэж, цахим системд байршуулсан хичээлийг тус бүрд товч дурдвал,



Шүүхийн эрх зүй

Тус сургалтыг Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Д.Азжаргал удирдан, 1 цагийн 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.

Шүүгчийн ёс зүй

Тус сургалтыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч А.Сарангэрэл удирдан, 2 цаг 15 минутын 3 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



Хичээлийн агуулга:

1. Шүүгчийн хараат бус байдлын тухай ойлголт, түүний Үндсэн хуулийн эрх зүйн үндэс
2. Шүүгчийн хараат бус байдлын бүрдэл хэсэг: албаны болон хувийн хараат бус байдал
3. Шүүгчийн болон хуульчийн баримтлах нийтлэг үүрэг, түүний агуулга
4. Ёс зүйн кодекс
- 5-8. Кэйс судлал №1-4



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



Агуулга

- Ёс зүйн онолын үндсэн ойлголт
- Шүүгчийн ёс зүйн үндсэн ойлголт
- Шүүгчийн ёс зүйн үндсэн 6 зарчим, Шударга ёсны зарчим (Integrity), Хараат бус байдлын зарчим (Independence), Төвийг сахих зарчим (Impartiality), Тэгш байдлын зарчим (Equality), Зохиотой байдлын зарчим (Propriety)
- Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ, сахилгын хэм хэмжээний ялгаа
- Шүүгчийн сахилгын зөрчил
- Сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, үзэл санаа
- Шинэ шүүгч өмнөх ажлаасаа бүрэн тусгаарлагдах шаардлага
- Шүүхэд хандах эрхийг хангахад анхаарах зүйлс
- Татгалзлын асуудалд анхаар зүйлс
- Цаашид судлах санал болгох ном, кино, видео хичээлийн талаар

Шүүгчийн хараат бус байдал ба хариуцлага

Тус сургалтыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Мөнх-Эрдэнэ удирдан, 2 цаг 30 минутын 5 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.

Шүүхийн сэтгэл зүй, шүүгчийн харилцаа хандлага

Тус сургалтыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн сэтгэл зүйч Б.Нямаа удирдан, 1 цаг 10 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Иргэний хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй

Тус сургалтыг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны Ерөнхий шүүгч Ж.Оюунтунгалаг удирдан, 2 цагийн 5 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



СЭДЭВ 1. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН СУУРЬ ЗАРЧМУУД, ИРГЭНИЙ ХУУЛЬ ТАЙЛБАРЛАХ АРГА ЗҮЙ

Сэдвийн зорилго: Иргэний эрх зүйн суурь болон тусгай зарчмуудын хүрээнд Иргэний хуулийн зохицуулалтыг зөв тайлбарлаж хэрэглэх чадварыг сайжруулах.

- Зарчмуудын хоорондын уялдаа холбоо, хуулийн заалт
- Бүх маргаан-бүрэн бүтэн, тодорхой, хангалттай шийдэл
- Ирээдүйд үүсэх тохиолдол
- Шүүгч маргааны үйл баримт-дотоод итгэл
- Хууль тайлбарлах аргыг зөв сонгож хэрэглэх

Эрүүгийн хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй

Тус сургалтыг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн нийтийн эрх зүйн тэнхимийн багш, доктор Т.Золбоо удирдан, 1 цаг 40 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн



Хууль ёсны зарчим

I. Хууль үгүй бол гэмт хэрэг үгүй

Эрх зүйт төрийн баталгаа

Агуулгын хувьд хүний хийсэн үйл нь бусдад хэцээн хортой, хохиролтой байсан ч тухайн үйлийг үйлдэхээс өмнө түүний хууль зүйн шинжийг эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээнд хийсвэрлэх байдлаар тодорхой хориглож хуульчлаагүй бол гэмт хэрэгт тооцоггүй гэх санааг илэрхийлнэ

II. Хууль үгүй бол ял үгүй

Захиргааны хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй

Тус сургалтыг Улсын дээд шүүхийн шүүгч Г.Банзрагч удирдан, 1 цаг 40 минутын 3 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.

Нотлох баримт, түүнийг үнэлэх /Иргэн/

Тус сургалтыг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Оюунтуяа удирдан, 1 цагийн 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн



Хэрэг, маргааны үйл баримтыг тогтоох

- Хэргийн оролцогчдын хооронд үүссэн эрх зүйн маргаантай харилцаа болон маргааны зүйлийг тодорхойлох нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх нөхцлийг бүрдүүлдэг.
- Эрх зүйн маргаантай харилцааг зөв тогтоохын тулд хэргийн нөхцөл байдал хангалттай бүрэн тогтоогдсон байх ёстой.
- Хэргийн бүх нотлох баримтыг шинжлэн судалж үзсэний эцэст талуудын хооронд ямар харилцаа үүсч, хэн ямар үүргээ хэрхэн биелүүлсэн, эсхүл биелүүлээгүй, маргаан ямар асуудлаар хэрхэн үүссэн нь тодорхой болсон тохиолдолд шүүх маргааныг таслаж, шийдвэрээ гаргах боломжтой болдог.

Нотлох баримт, түүнийг үнэлэх /Эрүү/

Тус сургалтыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр удирдан, 1 цаг 40 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн



Нотлох баримт, түүнийг үнэлэх нь:

ЭХХШТХ-ийн 16.2 дугаар зүйл. Нотолбол зохих байдал

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд нотолгооны зүйлийг тодорхойлсон буюу шүүхэд шилжүүлж буй эрүүгийн хэрэгт нотлох баримтад тулгуурлан заавал тогтоох, батлах эсхүл няцаах нөхцөл байдлуудын жагсаалтыг тусгасан болно.

Нотлох баримт, түүнийг үнэлэх /Захиргаа/

Тус сургалтыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан заалдах шатны шүүхийн шүүгч Г.Мөнхтулга удирдан, 1 цаг 15 минутын 3 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



Захиргааны процессын эрх зүйн диспозитив болон мөрдөн шалгах зарчим нь шүүхээс хэрэг, маргааны үйл баримтыг тогтоох асуудлын цар хүрээг тодорхойлдог болохгүй /шүүхийн хяналтын хэсгээр/.

Маргааны үйл баримтыг тогтоох:

- нэхэмжлэлийн зүгээс хариуцагч захиргааны байгууллагын ямар хууль бус үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрсэн зөрчигдөж, хөндөгдөж байгаа, түүнийгээ хэрсэн сэрээлэхийг хүсэж байгаа болохоо тодорхойлсон нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлээр,
- хариуцагчийн хувьд тухайн нэхэмжлэлийн шаардлагад хамаарах захиргааны актыг гаргахтай холбоотойгоор Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор хүлээн чиг үүргээ хэрсэн хэрэгжүүлсэн талаарх тайлбар, түүнд хамаарах нотлох баримтыг гаргаж өгөх үүргээр,
- захиргааны хэргийн шүүхийн хувьд хэргийн оролцогчдоос гаргасан шаардлага болон татгалзал, тэдгээрт холбогдох нотлох баримтыг цутгуулж, бэхжүүлэхтэй холбогдсон цогц ажиллагааг нэрхэвчлэн.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106.5-д заасанчлан "нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хэрсэн болон хэргийн оролцогчдын маргаагүй асуудлаар дүгнэлт хийж, шийдвэр гаргаж болохгүй".

Шүүх хуралдаанд бэлтгэх, хуралдаан удирдах /Иргэн/

Тус сургалтыг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Оюунтуяа, удирдан 30 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх

- ❖ Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн гэж шүүгч үзсэн.
- ❖ Энэ хуулийн 71.1-д заасан хугацаа дууссан
- ❖ Шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдол

Шүүх хуралдаанд бэлтгэх, хуралдаан удирдах /Эрүү/

Тус сургалтыг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Одонтуул удирдан, 45 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



Сэдвийн зорилго

- Шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай процессийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх мэдлэг, чадварыг ахиулах;
- Эрүүгийн хэргийн шүүн хуралдааныг хуульд заасан дэгийн дагуу явуулж талуудад хүндэтгэлтэй хандах;
- Ялгаварлан гадуурхахгүй байх, нэг талыг баримтлахгүй эрх тэгш байх;
- Шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хараат бус байж гагцхүү хуульд захирагдаж мэдрэмжтэй, ёс зүйтэй хандах;
- Шүүх хуралдааныг удирдах үр чадварт суралцах.



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



Шүүх хуралдааны зарчим

а/ Шүүхэд мэдүүлэх эрх

Захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийн шаардлага, түүний агуулгын хүрээнд хэргийг шийдвэрлэдэг тул шүүх хуралдааныг энэ хүрээнд явуулна. Шүүгч шүүх хуралдаанд нэхэмжлэлийн шаардлага, агуулга, түүнийг няцаасан тайлбарыг бүрэн дүүрэн гаргах боломжийг хэргийн оролцогчдод олгох үүрэгтэй.

Шүүх хуралдаанд бэлтгэх, хуралдаан удирдах /Захиргаа/

Тус сургалтыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч С.Мөнхжаргал удирдан, 55 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.

Мэтгэлцэх зарчим

Тус сургалтыг Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Батаа, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор, криминологич Б.Батзориг нар хамтран удирдаж, 1 цаг 5 минутын контент бэлтгэн цахим системд байршуулсан.





Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



Агуулга

- Шүүхийн шийдвэр хууль ёсны байхад ямар шаардлагууд тавигддаг вэ?
- Үндэслэлтэй бүхий байх шаардлагын гол агуулга юунд орших: Үүнийг хангахад ямар нөхцөлүүд шаардлагатай вэ?
- Шүүхээс гарах бусад актуудын онцлог юу вэ?
- Шүүхийн шийдвэр болон шүүхээс гарах бусад эрхийн актууд агуулга, хэлбэрийн шаардлага хангасан байхын ач холбогдол юу вэ?

Шүүхийн шийдвэр гаргах /Иргэн/

Тус сургалтыг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч Ж.Оюунтунгалаг удирдан, 1 цаг 10 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.

Шүүхийн шийдвэр гаргах /Эрүү/

Тус сургалтыг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Одонтуул удирдан, 20 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



Шүүхээс гарах актын төрөл, бүтэц, бичих арга техник

Шүүхийн шийдвэр нь анхан шатны шүүхээс шүүгдэгчийн гэм буруутай эсхүл гэм буруутгүйг тогтоож, түүнд ял оногдуулах, эсхүл ялаас чөлөөлөх тухай шийдвэр бөгөөд эцсийн шийдвэр гэх шийтгэх болон цагаатгах тогтоолыг зөвхөн "Монгол Улсын нэрийн өмнөөс" гаргаж, ЭХХШгХ болон ЭХ-ийг хэлбэртгүй сахина.

Шүүхээс хянан шийдвэрлэсэн хэрэг бүрийн талаар гаргасан шийдвэр хууль ёсны ба үндэслэлтэй байх ёстой.

Өөрөөр хэлбэл, хууль ёсны байна гэдэг нь ЭХХШгХ-д бүрэн нийцсэн, ЭХ болон бусад хуулийг зөв хэрэглэсэн байхыг ойлгоно.



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



Агуулга:

1. Захиргааны хэргийн шүүхээс гарах шийдвэрийн төрөл, онцлог
2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн бүтэц, хоорондын уялдаа
3. Шүүхийн шийдвэр боловсруулахад тавигдах хэлбэрийн шаардлага

Шүүхийн шийдвэр гаргах /Захиргаа/

Тус сургалтыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч С.Мөнхжаргал удирдан 45 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.

Хялбаршуулсан болон шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх

Тус сургалтыг Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвийн судлаач Б.Хонгорзул удирдан 8 55 минутын видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



Сургалтын зорилго

- Хялбаршуулсан болон шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх тухай онол, практикийн мэдлэгтэй болох
- Талуудад ХХША-ны тохиромжтой үе шатанд шүүхийн бус аргыг санал болгох
- Талуудыг эвлэрүүлэх үр чадварт суралцах



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



Шүүгчийн ажил танаас ямар арга барилаар ажиллахыг шаарддаг вэ?

- ❖Хурдтай, хуулийн дагуу процесс ажиллагааг удирдахыг;
- ❖Нягт нямбай, няхуур, өндөр анхаарал төвлөрлийг;
- ❖Ажлаа нарийн төлөвлөхийг;
- ❖Цаг хугацаандаа, цаг алдалгүй шүүхийн шийдвэр, шүүхийн процессыг явуулахыг;
- ❖Ажлын цагийн ихэнх хувийг шүүн таслах ажилд зарцуулахыг;
- ❖Үндэслэгээтэй, чанартай шүүхийн шийдвэрийн боловсруулахыг;
- ❖Үр нөлөөтэй, бүтээмжтэй ажиллахыг;
- ❖Эерэг хандлага, харилцааг.

Шүүгчийн ажлын зохион байгуулалт

Тус сургалтыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч А.Сарангэрэл удирдан 8 45 минутын видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.

Хэргийн хөдөлгөөний удирдлага /Эрүүл

Тус сургалтыг Хэргийн хөдөлгөөн хариуцсан референт Б.Батцэцэг удирдан 8 35 минутын видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



ЖАГСААЛТЫН ӨНГӨ

№	Төрөл	Хүлээн авсан, ХХША
1	Цагаан	Хүлээн авсан, ХХША
2	Шар	ШХ төвлөрсөн
3	Ногоон	Шийдвэрлэсэн, ДЭШД-д шийдвэрлэсэн, ХХШД-д шийдвэрлэсэн
4	Улаан	Түдгэлзүүлсэн
5	Цэнхэр	ДЭ, Хн шатны шүүхэд хүргүүлсэн
6	Ягаан	Архивласан

ХУГАЦААНЫ ТЕКСТИЙН ӨНГӨ

№	Төрөл	Хүлээн авсан, ХХША
1	Цагаан	Хүлээн авсан, ХХША
2	Шар	ШХ төвлөрсөн
3	Ногоон	Шийдвэрлэсэн, ДЭШД-д шийдвэрлэсэн, ХХШД-д шийдвэрлэсэн
4	Улаан	Түдгэлзүүлсэн
5	Цэнхэр	ДЭ, Хн шатны шүүхэд хүргүүлсэн
6	Ягаан	Архивласан



Шүүхийн сургалт,
судалгаа, мэдээллийн
хүрээлэн



2. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН НЭГДСЭН СИСТЕМЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Захиргааны хэргийн шүүхийн ачаалал жилээс жилд нэмэгдсээр байгаа бөгөөд анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхүүдийн хоорондын уялдаатай, нэг хэргийн шийдвэрлэлтийн явцыг цогцоор нь харах, тухайн шүүх тус бүр дээр ХХШ процессыг хянах, шүүгч, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нарын ажлыг хөнгөвчлөх зориулалтын программ хангамж байхгүйгээс анхан, давж заалдах шатны шүүхэд "ХХША"-ны алдаа нэлээд гарч байсан.

Хэргийн хөдөлгөөний удирдлага /Захиргаа/

Тус сургалтыг Хэргийн хөдөлгөөний бүртгэл, дүн шинжилгээ хариуцсан ахлах шинжээч М.Сэлэнгэ удирдан 8 30 минутын видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Хэргийн хөдөлгөөний удирдлага /Иргэн/

Тус сургалтыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэргийн хөдөлгөөн хариуцсан референт Ч.Ханддулам удирдан, 20 минутын видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.

Шүүгчийн нийгмийн мэдрэмж

Тус сургалтыг Судлаач С.Билгүүн удирдан, 1 цаг 25 минутын 3 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.



Шүүхийн практик судлал

Тус сургалтыг ШЕЗ-ийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвийн судлаач Б.Хонгорзул удирдан, 45 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан.

3. Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмыг хэрэглэх талаар болон Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмыг хэрэглэх талаар

Тус сургалтыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав удирдан, 30



Шүүхийн шийдвэрийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлэх шаардлага

Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлж тайлбарлах нь:

1. Шүүгчийн хувийн сонирхол, албаны эрх ашгийг нийцнэ:

- Мэдээллийн хоосон орон зай:
 - ашиглана - санаатай гүтгэлэг, гуйвуулсан мэдээ тараана
 - ам дамжсан худал мэдээлэл, сөрөг таамаглал тарна
 - хянах боломжгүй /цахим орон зай - хурдтай/
- Бодит болон бодит бус сөрөг мэдээлэл:
 - албаны нэр хүүдэл халтай
 - "шүүгч" -ийн албан тушаал - систем бүхэлдээ өртөнө
 - хувь шүүгчид нөлөөлж байна
 - шүүгчийг нэр зургаар нь таниулах, сошиал "bully"



минутын контент бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 119 шүүгч хамрагдсан байна.

Тус сэдвийн хүрээнд Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа удирдан, 53 минутын контент бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 121 шүүгч хамрагдсан байна.

4. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийг хохирогч төвтэй хянан шийдвэрлэх ажиллагаа

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн 72 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг Монгол Улсын гавьяат багш, доктор, дэд профессор Х.Баавгай, Сүхбаатар дүүргийн ГБХЗХХ-ийн дарга Л.Бадамцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Одонтуул нар удирдан, 4 цаг 5 минутын 7 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 141 шүүгч хамрагдсан байна.

Хүйс ба жендэр

Хүйс нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байгалиасаа харилцан адилгүй, төрөлхийн шинжтэй **биологийн** ойлголт.

Харин **"Жендэр"** гэдэг нь аль нэг нийгмийн зүгээс эрэгтэй, эмэгтэй хүмүүс хийгээд охид, хөвгүүдийн хувьд гүйцэтгэх ёстой гэж үздэг **үүрэг, зан байдал, үйлдэл, хандлага, боломж бололцооны** агуулгыг илэрхийлсэн ойлголт юм.

Жендэр нь хэдийгээр хүний биологийн хүйсийн байдлаас хамаардаг боловч агуулгын хувьд ялгаатай.

Тодорхойлолт:

Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ;

(Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай МУ-ын 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн хуулийн 4.1.1).

Монгол Улсын төрийн бодлого

Төрийн байгуулалтын мэдээллийн ил тод байдлыг гүйцэтгэх

Төрийн байгуулалтын үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хувьд оролцоог нэмэгдүүлэх

Төр өөрт байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг хангах

Цахимвар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид түргэн шуурхай, чиглэсэнгүй хүргэх

Төр болон иргэний цаг хугацаа, зардалыг хамнах

Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөгт, удирдлагар хангах

5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн үзэл баримтлал, онцлог зохицуулалт

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 26 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг Хууль зүйн

дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг удирдан, 1 цагийн 3 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 139 шүүгч хамрагдсан байна.

6. Зөвшөөрлийн тухай хуулийн үзэл баримтлал, онцлог зохицуулалтууд

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 26 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Мөнх-Эрдэнэ удирдан, 1 цагийн 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 36 шүүгч хамрагдсан байна.



7. Гэмт хэрэг зүйлчлэлийн онолын зарим асуудал ба тодорхой төрлийн гэмт хэрэг

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 26 тоот захирамжаар баталсан.


Тус сургалтыг Сонгинохайрхан дүүргийн

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Батаа удирдан, 3 цагийн 6 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 15 шүүгч хамрагдсан байна.

8. Чөлөөтэй, аюулгүй байх эрх

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 07 дугаар сарын 5-ны өдрийн 45 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, хууль зүйн доктор Б.Энхболд удирдан, 1 цагийн 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 182 шүүгч хамрагдсан байна.



“ЭРХ”-ийн ХЭЛБЭРҮҮД

- Hohfeld-ын ангилал
- “Эрх”-ийн 4 элемент
 - the privilege (a)-эрх чөлөө
 - the claim (p)-шаардах эрх
 - the power (a)-эрх хэлбэр
 - the immunity (p)-халдшгүй байдлыг
- Active – passive
- Negative – positive (p)

9. Шүүх, маргаан таслах байгууллагын өмнө тэгш байх, шударгаар шүүлгэх эрх

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 07 дугаар сарын 5-ны өдрийн 45 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг Улсын дээд шүүхийн шүүгч, хууль зүйн ухааны

доктор Ц.Цогт удирдан, 1 цагийн 45 минутын 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 171 шүүгч хамрагдсан байна.

10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд процессын хуулийг зөв хэрэглэх, нэгдмэл байдлыг хангах нь /Хүний эрхийн зарим зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь/

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 7 дугаар сарын 5-ний өдрийн 45 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Батаа удирдан 2 цагийн 2 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 43 шүүгч хамрагдсан байна.

UPR-ЫН ҮЙЛ ЯВЦ

- Хүний эрхийн зөвлөлийн 47 гишүүн улс удирдан явуулна.
- Засгийн газар үндэсний илтгэлүүдээ 4-5 жил тутам хэлэлцүүлнэ.
- НҮБ-ын хүний эрхийн болон төрөлжсөн байгууллагууд мэдээлэл нэгтгэж ирүүлнэ. Уг мэдээллийг ХЭДКГ бэлтгэнэ.
- Хүний эрхийн үндэсний байгууллагууд төрийн бус хөндлөнгийн илтгэлээ хүргүүлнэ.

МЭТГЭЛЦЭХ УР ЧАДВАР

11. Мэтгэлцэх ур чадвар

Азийн сангийн санхүүжилтээр Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн, Монголын Хуульчдын холбоотой хамтран шүүгч, прокурор, өмгөөлөгч, хуульчдын хууль хэрэглээний

нэгдмэл байдлыг хангах, жишиг тогтоох зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд “Мэтгэлцэх ур чадвар” сэдэв сургалтын цуврал контентыг бүтээсэн. Контент нь үндсэн 6 хэсгээс бүрдэнэ:



- Шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан шийдвэрлэх үндсэн шүүх хуралдаан (Эрүүгийн хуулийн 10.6 дугаар зүйл) – 1 цаг 23 минут;
- Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх шүүх хуралдаан – 17 минут.

Энэхүү сургалтын контентыг 20 шүүгч үзэж, танилцсан байна.



- Таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн анхны хэлэлцүүлэг – 29 минут;
- Таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх шүүхийн хэлэлцүүлэг – 19 минут;
- Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг – 18 минут;
- Шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан шийдвэрлэх үндсэн шүүх хуралдаан – 1 цаг 27 минут;



12. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах болон шүүгчид болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох

Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 26 тоот захирамжаар баталсан.

Тус сургалтыг ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Э. Пүрэвбаатар, ШЕЗ-ийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвийн судлаач-багш Б.Нямаа, ШЕЗ-ийн Шүүхийн аюулгүй байдал, стандарт хариуцсан референт Ц.Амарсанаа, ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа, Б.Наранболд нар тус тус удирдан 2 цаг 45 минутын 8 хэсэг видео хичээл бэлтгэн цахим системд байршуулсан. Сургалтад 77 шүүгч хамрагдсан байна.



Lerntheorien - Behaviorismus

- ca. 1900 – 1960er)
- Lernen = Verhaltensänderung durch Stimulus und Response (Reiz-Reaktion)
- Lehren = Assoziation und Verstärkung zwischen Reiz und Reaktion
- Klassische und Operante Konditionierung

Behaviourism
learner = black box
viewpoint of learning = external


Diagram illustrating the black box model of behaviorism: stimulus by teacher → Black Box (learner) → observable output. A feedback loop shows the teacher using feedback from the output to adjust the stimulus until desired behavior is reached.

13. “Сургахуйн заах арга зүй” сэдэвт шүүгч сургагч-багш бэлтгэх сургалт


Хүрээлэн Ханнс-Зайделийн сангийн дэмжлэгтэйгээр шүүгч-сургагч багш нарт зориулсан “Сургахуйн заах арга зүй” сэдвийн хүрээнд цахим хэлбэрээр зохион байгуулсан. Сургалтыг ХБНГУ-ын Лейпцигийн Их сургуулийн магистр Катарина Боныхади ерөнхий заах

арга зүйн онол, цахим, танхим болон хосолсон сургалтын заах арга зүй, шинэлэг аргаар заах-сурах арга хэрэгсэл буюу боловсролын шинэлэг технологи зэрэг агуулгаар удирдан явуулсан юм. Сургалтад 27 шүүгч-сургагч багш хамрагдаж, багц цагаа тооцуулсан.

График 9. Цахим сургалттай танилцсан дундаж хувь



Түүнчлэн Шүүхийн сургалтын төвөөс цахим сургалтын танилцуулга (презентейшн) бэлтгэх шинэ загвар гарган, сургалтын бичлэгийн өнгө, төрхийг өөрчлөн сургалтуудаа системд байршуулж байна.



Хүснэгт 10. 2023 онд видео хичээл бэлтгэн цахим системд байршуулахаар төлөвлөсөн хэдий ч бичлэг хийгдээгүй байгаа сургалт

Д/д	Сэдэв	Төрөл	Багц цаг	Тайлбар
1.	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн үзэл баримтлал, онолын зарим асуудал	Сонгон судлах	0.5	1 удаа танхимаар зохион байгуулж, танхимын сургалтын үеэр бичлэг дутуу хийгдсэн.
2.	Шүүгчийн ёс зүй, харилцаа, хандлага	Заавал судлах	0.5	Хөтөлбөр батлуулахаар УДШ-ийн Ерөнхий шүүгчид 12 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлсэн.
3.	Сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчийн сургалт	Заавал судлах	-	9 сэдвийн хүрээнд видео хичээл хийхээс 1 сэдвийн хичээлийн бичлэг хийгдсэн.

2.4. Шүүхийн сургалтын эрэлт, хэрэгцээний тандан судалгаа

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг “Шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулах, ...”, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3 дахь заалт “Шүүгчийн зөвлөгөөн шүүгчийг мэргэшүүлэх сургалтын саналаа Хүрээлэнд хүргүүлэх”-д заасныг тус тус удирдлага болгон 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1/280, 1/281, 1/282, 1/283, 1/284, 1/285, 1/286, 1/287, 1/288 дугаар бүхий албан бичгээр Улсын дээд шүүх, Эрүү, Иргэний хэргийн давж заалдах болон анхан шатны шүүх, Захиргааны хэргийн давж заалдах болон анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчдэд 2024 онд зохион байгуулах сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгааны асуулгыг боловсруулан шүүхийн Тамгын газруудаар уламжлан хүргүүлсэн.

Уг санал, асуулгын дагуу шүүхүүд Шүүгчдийн зөвлөгөөнөөр сургалтын сэдэв, агуулгыг хэлэлцэн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийг дуусталх хугацаанд саналаа Хүрээлэнд ирүүлсэн.

Монгол Улсын хэмжээнд нийт 117 шүүх байгаагаас 91 шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнөөс 2024 онд зохион байгуулах шүүгчийн сургалтын сэдэв, чиглэл, хэлбэрийн талаар санал ирүүлсэн байна.

Эдгээр саналыг нэгтгэн Сургалтын хөтөлбөрийн хороонд танилцуулсан бөгөөд, Хорооноос 1/Үндсэн хууль, шүүгчийн ёс зүй, 2/Эрүүгийн эрх зүй, 3/Иргэний эрх зүй, 4/Захиргааны эрх зүйн чиглэлийн ажлын хэсгүүд байгуулж, эдгээр ажлын хэсэг судалгааны үр дүнд үндэслэн 2024 онд зохион байгуулах сургалтын сэдвийг тодорхойлохоор тогтсон.

Хүснэгт 11. Санал ирүүлсэн шүүх

№	Шүүх	Шүүхийн тоо	Санал ирүүлсэн шүүх	Санал ирүүлсэн шүүхийн эзлэх хувь
1.	Улсын дээд шүүх /Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхим/	1 /3 танхим/	1 /3 танхим/	100
2.	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	3	3	100
3.	Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	3	3	100
4.	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	1	1	100
5.	Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	19	17	89.4
6.	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	30	18	60

7.	Иргэний хэргийн анхан шатны шүүх	30	23	76.6
8.	Захиргааны хэргийн анхан шатны шүүх	22	20	90.9
9.	Сум дахь сум дундын шүүх	8	5	63
Нийт		117	91	77.7

ГУРАВ. ШҮҮХ, ШҮҮГЧИЙГ СУДАЛГААГААР ХАНГАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД


Шүүхийн судалгааны төв нь 2023 онд **нийт 57** судалгаа хийж гүйцэтгэсэн бөгөөд үүнээс шүүгчээс ирүүлсэн захиалгын дагуу хийж гүйцэтгэсэн судалгаа **50** бөгөөд шүүгчийн захиалгаар бус, төвийн чиг үүргийн хүрээнд **7** судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

График 10. Шүүхийн судалгааны төвийн 2023 онд хийж гүйцэтгэсэн судалгаа



Шүүхийн судалгааны төвийн секторууд нь захиалгат судалгааг салбар эрх зүйн чиглэлээр бие даан болон бусад сектортой хамтран хийж гүйцэтгэдэг. 2023 оны хувьд нийт захиалгат 50 судалгааны 4 судалгааг секторууд хамтран гүйцэтгэсэн бөгөөд 46 судалгааг секторууд бие даан гүйцэтгэсэн байна. Бие даан гүйцэтгэсэн 46 судалгааг сектор бүрээр төрөлжүүлэн үзвэл, Захиргааны эрх зүйн сектор - 15, Эрүүгийн эрх зүйн сектор - 16, Иргэний эрх зүйн сектор - 15 судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

График 11. Секторуудын бие даан хийсэн судалгаа




Тус төв нь бүх шатны шүүхийн шүүгчийн захиалгын дагуу нийт **50** судалгаа хийж гүйцэтгэсэн бөгөөд захиалагчаар нь авч үзвэл, УДШ-ийн шүүгчийн захиалгат судалгаа **43**, Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн захиалгат судалгаа **3**, Анхан шатны шүүхийн шүүгчийн захиалгат судалгаа **4** байна.

График 12. Захиалгат судалгааны захиалагчид



Шүүхийн судалгааны төв нь бүх шатны шүүх, шүүгч нарын судалгаа, мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд 2021 онд нийт **15** судалгаа, лавлагааг, 2022 онд нийт **44** судалгаа, лавлагааг хийж байсан бол 2023 онд нийт **50** судалгаа, лавлагааг шүүгчийн захиалгын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

График 13. Өмнөх онуудад судалгааны төвийн хийж гүйцэтгэсэн судалгаанууд



3.1. ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН СЕКТОР

Тус сектор нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийг хүртэлх бүтэн жилийн хугацаанд нийт бие даан **18** судалгааг хийж гүйцэтгэжээ. Үүнээс бие даан хийсэн захиалгат судалгаа **15**, чиг үүргийн хүрээнд хийсэн **3** судалгаа байна. Мөн дээрх судалгаанаас 1 судалгааны тайлангийн үр дүн УДШ-ийн хуулийн албан ёсны 1 тайлбарт эшлэгдсэн. Ташрамд, 2022 онд гүйцэтгэсэн 1 судалгааны үр дүн 2023 онд УДШ-ийн хуулийн албан ёсны 2 тайлбарт мөн эшлэгдсэн.

1. Улс төрийн намын бүртгэл хөтлөх талаарх Монгол Улсын зохицуулалтын өнөөгийн байдал болон гадаадын зарим улсын туршлага: Харьцуулсан судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч П.Соёл-Эрдэнийн ирүүлсэн захиалгын дагуу гүйцэтгэсэн бөгөөд улс төрийн намын бүртгэлийг гадаад улсад дээд шүүх эсхүл өөр байгууллага хөтөлдөг эсэх, нам байгуулах зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь ямар байгууллага байдаг, холбогдох хууль тогтоомжид хэрхэн зохицуулсныг Монгол Улстай харьцуулсан судалсан.

2. Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2, 48.3 дахь зохицуулалтын хууль хэрэглээ ба холбогдох газрын маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Х.Батсүрэнгийн ирүүлсэн захиалгын дагуу гүйцэтгэж, “К” болон “А” ХХК-уудын нэхэмжлэлтэй, Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргад холбогдох маргаанд хамаарах Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2, 48.3 дахь зохицуулалтын хэрэглээ, онолын үзэл баримтлал, шүүхийн практикийг судалсан.

3. Зөрчлийн тухай хуулийн 11.30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтын хууль хэрэглээ ба холбогдох зөрчлийн маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч П.Соёл-Эрдэнийн ирүүлсэн захиалгын дагуу гүйцэтгэж, “К” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагч нарт холбогдох маргаанд хамаарах Зөрчлийн тухай хуулийн 11.30 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын хэрэглээ, онолын үзэл баримтлал, шүүхийн практикийг судалсан.

4. Төрийн аудитын тухай хууль болон Газрын тосны тухай хуулийн зарим зүйл, заалтын хууль хэрэглээ, төрийн хяналт шалгалтын маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Д.Батбаатарын ирүүлсэн захиалгын дагуу гүйцэтгэж, “Д” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Монгол Улсын Ерөнхий аудитор болон аудиторуудад холбогдох маргааны гол зүйл болох аудитын тайланг баталгаажуулсан Ерөнхий аудиторын тушаал дангаараа захиргааны акт болох эсэх, аудитор нь бүтээгдэхүүн хуваах гэрээний зохицуулалтыг хуульд харьцуулан тайлбарлаж, дүгнэлт гаргах эрхтэй эсэх тухай хууль хэрэглээтэй холбоотой асуудлыг судалсан.

5. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийн хууль хэрэглээ: Газар, төрийн алба, ашигт малтмал, улсын бүртгэлийн маргааны төрлөөр авч үзэх нь

Тус судалгааг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч С.Мөнхжаргалын ирүүлсэн захиалгын дагуу гүйцэтгэсэн бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах зохицуулалтыг анхан болон давж заалдах шатны шүүхүүд хэрхэн тайлбарлаж, хэрэглэж байгааг маргааны салбар эрх зүйн төрөл (газар, төрийн алба, ашигт малтмал, улсын бүртгэл)-өөр нэг бүрчлэн авч үзэж, дүн шинжилгээ хийх, улмаар захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох арга зам

эрэлхийлэх, санал, зөвлөмж дэвшүүлэх зорилгоор нийслэл, орон нутгийн захиргааны хэргийн анхан, давж заалдах шатны 23 шүүхийн 2020.12.20-2022.12.31-ний хооронд гаргасан захирамж, түүнийг хянасан тогтоолыг нэг бүрчлэн судалсан.

6. Газрын маргаан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тогтоолын судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяагийн захиалгын дагуу гүйцэтгэж, УДШ-ийн сүүлийн 5 жил (2018-2023)-ийн хугацаанд шийдвэрлэсэн газрын маргаан, тэр дундаа тусгай хамгаалалттай газарт газар ашиглах эрх олгосон маргаан бүхий акттай холбоотой маргаануудад дүн шинжилгээ хийж, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон субъектээр ангилан судалсан.

7. Улс төрийн намын бүртгэлийн талаарх гадаад улсын зохицуулалтын харьцуулсан лавлагаа

Тус лавлагааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяагийн захиалгын дагуу гүйцэтгэсэн бөгөөд анхан шатны шүүх, эсхүл Дотоод хэргийн яам улс төрийн намын бүртгэлийг хөтөлж, бүртгэлд хамаарах шийдвэрийг давж заалдах журмаар Дээд шүүх эсхүл Давж заалдах шатны шүүх нь хянах зохицуулалттай Болгар, Чех, Польш, Словак, Румын Улсын хууль тогтоомжийг харьцуулсан судалсан.

8. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.2, 47.7 дахь заалтад холбогдох практик судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Г.Банзрагчийн захиалгаар гүйцэтгэж, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.2 болон 47.7 дахь заалтыг хэрэглэн шийдвэрлэсэн хооронд шийдвэрлэсэн УДШ-ийн 2019.11.22-2023.04.20-ны хооронд дахь тогтоолыг түүвэрлэж, дүн шинжилгээ хийсэн.

9. Захиргааны актыг илт хууль бус болохыг тогтоолгох, хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагад холбогдох зарим асуудал болон холбогдох газрын маргааныг хяналтын журмаар шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч П.Соёл-Эрдэнийн ирүүлсэн захиалгын дагуу гүйцэтгэж, “М” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Дархан-Уул аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт тус тус холбогдох маргаанд хамаарах шүүх санаачилгаараа нэхэмжлэлийн шаардлага, ялангуяа захиргааны актыг илт хууль бус болохыг тогтоолгох, хүчингүй болгуулах шаардлагыг өөрчилж болох асуудлыг тухайлан судалсан.

10. Шүүгчийн эрх зүйн байдлыг зохицуулсан Монгол Улсын болон гадаадын зарим улсын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа

Тус судалгааг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Гангэрэлийн ирүүлсэн захиалгын дагуу гүйцэтгэж, шүүгчийг Монгол Улсын хууль тогтоомжоор төрийн албан хаагч гэж үзэх эсэх, холбогдох хуулиудын үзэл баримтлал, хууль тогтоогчийн үзэл санаа болон Япон,

ХБНГУ, Испани Улсад шүүгчийг төрийн албан хаагч мөн эсэхийг хэрхэн зохицуулсныг харьцуулан судалсан.

11. Хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн гэх үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэн шийдвэрлэсэн шүүхийн сахилгын хорооны шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

Тус судалгааг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн захиалгаар гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.23-т заасан үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэн шийдвэрлэсэн Шүүхийн сахилгын хорооны шийдвэрт нэг бүрчлэн дүн шинжилгээ хийсэн.

12. Гадаадын зарим улсын дээд шүүхийн тамгын газрын бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүргийн талаарх харьцуулсан судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Ц.Цогтын ирүүлсэн захиалгын дагуу гүйцэтгэж, УДШ-ийн Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн боловсруулахтай холбогдуулан Япон, ИБУИНХУ, Эстони, Латви улсын Дээд шүүхийн Тамгын газрын бүтцийг харьцуулан судалсан.

13. Үндсэн хуулийн шүүхээс үндсэн эрхийн маргаан шийдвэрлэх болон Дээд шүүхийн шүүгч Үндсэн хуулийн шүүхийн гишүүнээр томилогдохтой холбоотой харьцуулсан судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Ерөнхий шүүгч Д.Ганзоригийн ирүүлсэн захиалгын дагуу гүйцэтгэсэн. Судалгааны хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд УДШ санал хүргүүлэхэд шаардлагатай судалгаагаар хангах зорилгоор Үндсэн эрхийн маргаан шийдвэрлэх үндсэн хуулийн шүүхийн туршлага болон УДШ-ийн шүүгчийг үндсэн хуулийн шүүхийн гишүүнээр томилдог эсэх талаар монгол хэлээр бичсэн бүтээл, судалгааны эх сурвалжийг нэгтгэн тоймлож, ХБНГУ, Литва, ОХУ, Болгар улсын Үндсэн хуулийн шүүхэд үндсэн эрхийн маргаан шийдвэрлэх, дээд шүүхийн шүүгчийг үндсэн хуулийн шүүхийн гишүүнээр томилдог эсэх туршлагыг харьцуулан судалсан.

14. Хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн гэх үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэн шийдвэрлэсэн шүүхийн сахилгын хорооны шийдвэрт хийсэн дүн шинжилгээ (Нэмэлт хувилбар)


Тус судалгааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяагийн захиалгын дагуу гүйцэтгэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.23 дахь заалтад заасан үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэн шийдвэрлэсэн Шүүхийн сахилгын хорооны 2021.01.10-ны өдрөөс 2023.09.30-ны хооронд дахь 69 магадлал, 4 тогтоолд дүн шинжилгээ хийсэн.

15. Ерөнхий шүүгчийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх харьцуулсан судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Ерөнхий шүүгч Д.Ганзоригийн захиалгаар гүйцэтгэж байгаа бөгөөд Австри, ОХУ, Чех, Хорват, Литва улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг харьцуулан судалж байна.

Дээр дурдсанчлан УДШ болон анхан, давж заалдах шатны шүүхийн шүүгчийн захиалгын дагуу тус сектор бие даан хийж гүйцэтгэсэн **нийт 15 судалгаа** байна. Эдгээр 15 судалгааны 6 судалгаа нь харьцуулсан судалгаа, 9 нь практикийн судалгаа байна.

График 14. Шүүгчийн захиалгын дагуу Захиргааны эрх зүйн секторын гүйцэтгэсэн судалгааны төрөл



Б. Бусад судалгааны жагсаалт: (захиалгын хуудасгүй хийж гүйцэтгэсэн судалгаа)

1. Хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн гэх үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэх нь: Монгол Улс ба гадаадын зарим улсын зохицуулалт

Тус судалгааны хүрээнд Франц, Молдав, БНСУ, ОХУ, Испани, Итали Улсын зохицуулалтыг сонгон авч МУШТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1.23-т заасантай төстэй зохицуулалт бий эсэхийг харьцуулан судалсан. Энэхүү судалгааны үр дүнг 2023 оны 09 дүгээр сарын 28, 29-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Нийт шүүгчдийн хоёрдугаар чуулганд ШССМХ-ийн захирал Д.Эрдэнэчимэг танилцуулсан юм.

2. Хэрэг хуваарилах нийтлэг журмыг боловсронгуй болгох зарим асуудал

Тус судалгааны хүрээнд “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам”-ыг боловсронгуй болгох санал дэвшүүлэх зорилгоор эрүү, иргэн, захиргааны анхан, давж заалдах, УДШ зэрэг нийт 93 шүүхийн 2021 оны 10 дугаар сараас хойш батлан хэрэгжүүлж буй хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журамд нэг бүрчлэн дүн шинжилгээ хийж, Эстони, Польш, ОХУ-ын холбогдох эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсан. Энэхүү судалгааны үр дүнг 2023 оны 09 дүгээр сарын 28, 29-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Нийт шүүгчдийн хоёрдугаар чуулганд ШССМХ-ийн Шүүхийн судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн танилцуулсан юм.

3. Шүүхийн сахилгын хорооны 2023.04.01-2023.05.31-ний өдрийн хооронд сахилгын хэрэг шийдвэрлэсэн магадлалд нэг бүрчлэн хийсэн дүн шинжилгээ

Тус судалгааг Захиргааны эрх зүйн секторын хүрээнд тогтмол гүйцэтгэхээр болсон бөгөөд дүн шинжилгээний хамгийн эхний цувралаар Шүүхийн сахилгын хорооны 2023.04.01-2023.05.31-ний өдрийн магадлалд нэг бүрчлэн дүн шинжилгээ хийсэн. Одоогийн байдлаар дүн шинжилгээний нэгтгэсэн тайланг боловсруулж байна.

3.2. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОР

Тус сектор 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд бие даан **18** судалгаа хийж гүйцэтгэсэн бөгөөд захиалгат судалгаа **16**, чиг үүргийн хүрээнд **2** судалгааны тайлан гаргасан байна.

А. Бие даан хийж гүйцэтгэсэн судалгааны ажил

1. Шүүхийн шийдвэрт латин нэр томьёо хэрэглэх асуудал

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Амарбаясгалангийн ирүүлсэн захиалгын дагуу латин хэл ба хууль зүйн шинжлэх ухааны уялдаа холбоог судалсан. Ийнхүү судлахдаа латин хэлний гарал үүсэл, бусад шинжлэх ухаан ба хууль зүйн шинжлэх ухаанд гүйцэтгэх үүрэг, гадаадын зарим улс оронд латин хэлийг хууль тогтоомжид ашиглаж буй байдал, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн сургалтын хөтөлбөр зэргийг судалсан. Энэхүү судалгааг шүүхийн шийдвэрт хууль зүйн латин нэр томьёо ашиглах гарын авлагад зориулж гүйцэтгэсэн.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарим зарчмууд

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Амарбаясгалангийн ирүүлсэн захиалгаар орчин үеийн эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйд баримталж буй “Prima facie, bona fide” зэрэг зарчмуудыг гадаадын зарим улс оронд хэрэглэж буй байдлыг харьцуулан судалсан.

3. Баривчлах ажиллагааны талаарх харьцуулсан судалгаа

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч М.Пүрэвсүрэнгийн захиалгаар Герман, Америк, Хятад, Солонгос, Их Британи, Испани, Канад зэрэг улс орны баривчлах ажиллагааны процессыг харьцуулан судалсан. Энэхүү судалгааны үр дүн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгагдсан билээ. Түүнчлэн, Монгол Улсын дээд шүүхээс санаачлан зохион байгуулсан “Сэжигтнийг баривчлах ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт захиалагч илтгэж оролцсон.

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлтэй холбоотой практик судалгаа

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаярын ирүүлсэн захиалгын дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар давж заалдах болон

хяналтын шатны шүүхийн эрх хэмжээг хассантай холбоотойгоор эрүүгийн хэргийн бүх шатны шүүхэд тулгамдаж буй асуудлыг судалсан. Улмаар судалгааны үр дүнг Хууль зүй, дотоод хэргийн яаманд илгээх албан бичигт эшилсэн.

5. **Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт: харьцуулсан судалгаа**

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэнгийн ирүүлсэн захиалгын дагуу Орос, Хятад, Их Британи, Америк зэрэг улсад эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж буй туршлага, шүүхийн шийдвэрийн загварыг харьцуулан судалсан. Судалгааны үр дүнд Улсын дээд шүүхийн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүхийн шийдвэрийн жишиг загварыг баталсан.

6. **Jura novit curia зарчмын тухай ойлголт**

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Амарбаясгалангийн ирүүлсэн захиалгаар бусад улс оронд хэрэглэж буй зарчим, онолын үндэслэл, жишиг шүүхийн шийдвэр зэргийг харьцуулан судалсан.

7. **Эрүүгийн хэргийн шүүхийн харьяаллын талаарх судалгаа**

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаярын ирүүлсэн захиалгаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэргийн шүүхийн харьяаллыг тогтоож буй өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийхийн сацуу Их Британи, Хятад, Герман, Орос, Америк зэрэг улсад шүүхийн харьяаллыг хэрхэн тогтоож буйг харьцуулан судалсан.

8. **Давж заалдах, хяналтын шатны шүүхийн бүрэн эрх: хуулиар тусгайлан харьяалуулсан эрүүгийн хэрэг, эрх зүйн маргаан**

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаярын ирүүлсэн захиалгаар үе үеийн эрүүгийн процессын хууль, Шүүхийн тухай хуулиас “давж заалдах, хяналтын шатны шүүхэд хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг маргаан”-ыг түүхчлэн судалсан. Энэхүү судалгааны үр дүн авлигын дагнасан шүүх байгуулах эсэх хэлэлцүүлэгт дурдагдсан юм.

9. **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлд заасан эд мөрийн баримтын талаарх судалгаа**

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч М.Пүрэвсүрэнгийн ирүүлсэн захиалгаар эрүүгийн хэргийн бүх шатны шүүхэд нотлох баримтыг үнэлэхэд тулгамдаж буй асуудал, Их Британи, Америк, Герман, Солонгос, Казахстан болон Орос улсад эд мөрийн баримтыг үнэлэх туршлага, эрх зүйн зохицуулалт зэргийг харьцуулан судалсан. Энэхүү судалгааны үр дүнд 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёстой тайлбар”-ыг баталсан.

10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.7 дугаар зүйлд заасан тэмдэглэлийн талаарх судалгаа

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Цогтын ирүүлсэн захиалгын дагуу дотоодын хууль тогтоомж, журам, Орос, Герман, Америк зэрэг улсын хууль тогтоомжийг харьцуулан судалсан. Энэхүү судалгаа нь Эрүүгийн хэргийн танхимаас гарах цуврал эрүүгийн процессын тайлбарын суурь судалгаа болсон.

11. Мөрдөн шалгах нууц ажиллагааны талаарх харьцуулсан судалгаа

Энэхүү судалгааг УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимаас ирүүлсэн захиалгаар гадаадын зарим улс оронд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах зарчим, түүнийг олгох, шийдвэрлэх процессын хүрээнд харьцуулан судалсан.

12. Төрийн болон албаны нууцтай хэргийг хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг танилцуулах, гардуулах талаарх судалгаа

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Цогтын ирүүлсэн захиалгаар Америк, Орос, Герман, Япон улсад төрийн болон албаны нууцтай хэргийг хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг гардуулах процесс, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсан.

13. Хорих ялын хугацааг сонгон хэрэглэх арга зүйн талаарх судалгаа

Энэхүү судалгааг Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Батаагийн захиалгаар эх газрын болон жишгийн эрх зүйн тогтолцоотой орнуудыг төлөөлүүлэн 8 улсын Эрүүгийн хууль, ял оногдуулах удирдамжийг харьцуулан судалсан. Улмаар судалгааны үр дүнг Эрүүгийн хэргийн танхим, эрүүгийн хэргийн нийт шүүгчдийн хуралдаанд танилцуулж цаашид практикт хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлсэн. Түүнчлэн шүүгч-судлаачийн судалгааны ажлын эмхэтгэлд хэвлэгджээ.

14. Албан тушаалын гэмт хэргийн түүхчилсэн судалгаа

Энэхүү судалгааг УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаярын захиалгаар Богд хаант, социалист, шинэ, нэн шинэ үеийн Эрүүгийн хуулиудын авлига, албан тушаалын холбогдолтой гэмт хэргүүдийг түүхчлэн судалсан билээ. Ийнхүү судлахдаа тухайн хэм хэмжээний хууль зүйн шинж, ялын бодлого, гэмт хэргийн бүрэлдүүн, тусгай ангийн системчлэлийн хүрээнд авч үзсэн юм. Цаашид Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулахад ашиглагдахуйц суурь судалгаа болсон.

15. Хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээний талаарх харьцуулсан судалгаа


Энэхүү судалгааг Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Володъя-ын ирүүлсэн захиалгын гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээний онолын үндэс, зорилго болон Эстони, Герман, Орос, Америк улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулан судалсан.

16. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн харьцуулсан судалгаа

Энэхүү судалгааг УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын захиалгаар хийж гүйцэтгэжээ. Цаг үеийн шинжтэй асуудлын улмаас мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн шинжийг судлах хэрэгцээ шаардлага үүссэн билээ. Ийнхүү захиалга ирүүлсний дагуу Их Британи, Герман, Америк, Орос, Солонгос зэрэг улсын хууль тогтоомжоос эл гэмт хэргийн шинжийг харьцуулан судалсан. Судалгааны үр дүнд үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал хүргүүлэх ач холбогдолтой.

Дээр дурдсан захиалгат 16 судалгааг тус төвийн Эрүүгийн эрх зүйн сектор УДШ болон анхан шатны шүүхийн шүүгчийн захиалгын дагуу хийж гүйцэтгэсэн байна. Захиалгат судалгааг агуулгаар нь ангилан үзвэл, харьцуулсан судалгаа – 11, практик судалгаа-2, практик, харьцуулсан судалгаа – 2, түүхчилсэн судалгаа – 1 байна.

График 15. Шүүгчийн захиалгын дагуу Эрүүгийн эрх зүйн секторын хийсэн судалгааны төрөл



Б. Бусад судалгааны жагсаалт: (захиалгын хуудасгүй хийж гүйцэтгэсэн судалгаа)

1. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тодорхойлох арга зүйн талаарх судалгаа

Энэхүү судалгааг Сургалтын хөтөлбөрийн хорооны захиалгаар хийж гүйцэтгэсэн. Манай улсад мөнгө угаах гэмт хэргийг хуульчилсан үеэс эхлэн түүний суурь гэмт хэргийг тогтоох нь хууль тогтоогч, эрүүгийн эрх зүйн судлаачдын анхаарал хандуулсаар ирсэн сэдэв болжээ. Уг судалгаагаар бид суурь гэмт хэргийг тогтоох арга зүйг олон улсын шинжтэй эрх зүйн баримт бичгүүд, түүний тайлбар, хуулийн хувийн хэрэг, бусад улс орны (Америк, Солонгос, Итали, Хятад, Нидерланд,

Орос, Герман, Швейцар, Шинэ Зеланд) арга зүйтэй харьцуулан судалсан. Эл судалгаа нь цаашид шүүгчдийн сургалтын хөтөлбөр болохоор төлөвлөгдөж байна.

2. Хорих ялын хугацааг сонгон хэрэглэх арга зүйн талаарх судалгаа (нэмэлт)

Энэхүү судалгааг Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Батаагийн захиалгаар хийж гүйцэтгэсэн. Уг судалгааны нэмэлтээр Солонгос улсын ялын удирдамж, Япон улсын давж заалдах, хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ, Америк Нэгдсэн Улсын ялын зөрүү зэрэг сэдвийн хүрээнд дэлгэрүүлэн судалсан юм. Энэхүү судалгаа нь тус Хүрээлэнгийн эмхэтгэн гаргасан **“Шүүгч-судлаач: судалгааны ажлын эмхэтгэл” Цуврал-1**-т хэвлэгдсэн юм.

3.3. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН СЕКТОР

Иргэний эрх зүйн сектор 2023 оны 01 дугаар сарын 01-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт **17** судалгаа хийсэн бөгөөд үүний **15** нь шүүгчийн захиалгаар, шүүгчийн захиалгын бус **2** судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

А. Бие даан хийж гүйцэтгэсэн судалгааны ажил

1. Даатгалын эрх зүйн зарим ойлголтыг тайлбарлан хэрэглэхтэй холбоотой судалгаа

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын Н.Баярмаа шүүгчийн захиалгаар судалгааг гүйцэтгэхдээ зарим нэр томъёог анагаах ухааны болон эрх зүйн хувьд (тэр дундаа даатгалын эрх зүйд) хэрхэн тодорхойлдог талаар судалж, дотоодын эрх зүйн хэм хэмжээ болон харьцуулсан судлахаар сонгон авсан улсын эрх зүйн хэм хэмжээнд даатгалын эрх зүй, даатгалын ач холбогдлыг дэлгэрүүлэн судлахын зэрэгцээ “өвчин”, “гэнэтийн осол”, “осол” гэх ойлголтууд туссан эсэх, тийм бол тэдгээрийн агуулгыг дэлгэрүүлэн судалсан. Түүнчлэн харьцуулсан судалгааны хүрээнд энэхүү тохиолдолтой төстэй маргаан үүссэн бол хэрхэн шийдвэрлэсэн, энэ төрлийн маргааныг шүүхийн практикт ямар зарчим баримтлан хэрхэн шийдвэрлэдэг талаар болон даатгалын эрх зүйн маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практикийн хөгжлийн талаар авч үзсэн.

2. Шүүгчдийн зөвлөгөөний дэг, ерөнхий шүүгчийг сонгох, томилохтой холбоотой судалгаа (иргэний хэрэг)

УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа шүүгчийн захиалгаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.8, 36.9 дэх заалтуудыг анхан болон давж заалдах шатны шүүхүүд хэрхэн тайлбарлаж хэрэглэдэг болон шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг хүчингүй болгож буй тохиолдол, үндэслэлийн талаар иргэний хэрэгт холбогдох хэсгийн судалгааг гүйцэтгэж илгээв.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйл (эрх залгамжлал)-д холбогдох судалгаа

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын шүүгч Х.Эрдэнэсүвд шүүгчийн захиалгаар Монгол Улсын ИХШХШТХ-ийн 30 дугаар зүйл буюу

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авахтай холбоотой зохицуулалтын харьцуулсан судалгааг хийхийн зэрэгцээ Монгол Улсын нийслэлийн дүүрэг, орон нутгийн шүүхийн тамгын газартай судалгааны эх сурвалж цуглуулахаар хамтран ажиллаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх залгамжлагчаар тогтоолгох хүсэлтийг хэрхэн шийдвэрлэж байгаа байдал, энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлсөн эсэх талаар практик судалгааг хийж гүйцэтгэсэн болно.

4. **Үндэслэлгүйгээр цагдан хоригдсоноос үүссэн гэм хорын хохиролтой холбоотой маргааныг шийдвэрлэж буй практикийн судалгаа**

Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч З.Энхцэцэгийн захиалгаар Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас 2017 оноос 2023 оныг хүртэлх сүүлийн 6 жилийн хугацаанд хянан шийдвэрлэсэн нийт маргаанаас “үндэслэлгүйгээр цагдан хоригдсоноос үүссэн гэм хорын хохирол”-той холбоотой маргааныг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар практикийг судалсан.

5. **Олон улсын арбитрын шийдвэрийг биелүүлэх ажиллагааны эрх зүйн орчинтой холбоотой харьцуулсан судалгаа**

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг шүүгчийн захиалгаар Монгол Улсын олон улсын гэрээ буюу 1958 оны Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц, ийнхүү биелүүлэхээр татгалзах үндэслэлийн талаар онолын ойлголтоос гадна Япон Улс, Швейцарын Холбооны Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх зүйн зохицуулалтыг сонгон авч харьцуулан судалсан болно.

6. **Ажлын цагтай холбоотой олон улсын гэрээ, конвенц зөвлөмжийн талаарх мэдээлэл**

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын П.Золзаяа шүүгчийн захиалгаар Монгол Улсын нэгдэн орсон болон нэгдэн ороогүй олон улсын гэрээ, конвенц, зөвлөмжид тусгагдсан хөдөлмөрийн эрх зүйн ажлын цагийн зохицуулалтыг судаллаа. Ингэхдээ Монгол Улсын нэгдэн орсон болон нэгдэн ороогүй олон улсын гэрээ, конвенц, зөвлөмжөөс ажлын цагийн эрх зүйн зохицуулалтыг сонгон авч судалсан.

7. **Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг тайлбарлуулахаар УДШ-д ирүүлсэн хүсэлтэд холбогдох судалгаа**

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын Х.Эрдэнэсүвд шүүгчийн захиалгаар Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг тайлбарлуулахаар хууль батлагдсан цагаас хойш УДШ-д иргэн болон хуулийн этгээдээс ирүүлж байсан хүсэлтэд анализ хийн, ажлын цагтай холбогдох зохицуулалт болох Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 49.12, 50.2, 86.1, 90.1, 92, 87.3, 109, 102, 154, 156, 158 дугаар зүйлүүдэд хамаарах чиглэлээр ХБНГУ, Норвегийн Хант Улс, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс, Канад Улс, АНУ, Япон Улсуудын

эрх зүйн зохицуулалтыг болон Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдсанаас хойш монгол улсын шүүхээр хянан шийдвэрлэгдсэн маргааны тоон судалгааны хүрээнд судалгааг хийж гүйцэтгэсэн.

8. Тээвэр зуучийн гэрээний ойлголт ба гэрээний эрх зүйн харилцаатай холбоотой онцлог зохицуулалтын талаарх судалгаа

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын Н.Баярмаа шүүгчийн захиалгаар тээвэрлэлтийн гэрээ, тээвэр зуучийн гэрээ, комиссын гэрээ, худалдааны төлөөлөгч ба худалдааны зуучлагчийн тухай ойлголт ба гэрээний эрх зүйн харилцаатай холбоотой онцлог зохицуулалтын талаарх судалгааг хийж гүйцэтгэсэн. Энэ хүрээнд ХБНГУ, БНФУ болон Япон Улсыг хамруулан тэдгээрийн эрх зүйн зохицуулалт, тээврийн гэрээний стандарт, олон улсын гэрээ, конвенцод уг ойлголтыг хэрхэн авч үзсэн талаарх онолыг харьцуулан судалсан.

9. Векселийн тухай онолын ойлголт, түүнийг шүүхийн практикт хэрхэн тайлбарлан хэрэглэж буй талаарх судалгаа

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын П.Золзаяа шүүгчийн захиалгаар Векселийн тухай ойлголт, түүний тодорхойлолт, төрөл, хэлбэр болон векселээр үүргийн гүйцэтгэлийг хангах боломжтой эсэх талаарх онолын ойлголт болон шүүхийн практикт дүн шинжилгээ хийсэн бөгөөд ингэхдээ ХБНГУ, Их Британи Улс болон АНУ-ыг хамруулан онолын болон практикийн үүднээс судалсан.

10. Даатгалын нөхөн төлбөр олгох болон олгохоос татгалзах нөхцөл, үндэслэлд холбогдох шүүхийн практикийн судалгаа

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын Д.Цолмон шүүгчийн захиалгаар Даатгалын нөхөн төлбөр, түүнийг олгох болон олгохоос татгалзах нөхцөл, үндэслэлийг шүүх хэрхэн тайлбарлан хэрэглэдэг талаарх шүүхийн практикийг судалсан.

11. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлан хэрэглэхтэй холбоотой судалгаа

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын Н.Батзориг шүүгчийн захиалгаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн 33.1.2.4-т зохицуулсан “мал” гэх ойлголтод юу хамаарах талаар буюу “мал” нь “тэжээвэр амьтан”, “гэрийн тэжээвэр амьтан”-аас ойлголтын хувьд ялгаатай эсэх, мөн дээрх зүйл, заалтыг зохицуулах болсон хууль тогтоогчийн суурь үзэл баримтлал болон шүүхийн практикийг судалсан.

12. Дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооноос гарч буй шийдвэрийн эрх зүйн үр дагавар, түүний хэрэгжилттэй холбоотой судалгаа

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Д.Золзаяа шүүгчийн захиалгаар Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 158 дугаар зүйлийн 158.2 дах хэсэгт зохицуулсан үндэслэлийг шүүх хэрхэн тайлбарлан хэрэглэж буй талаар, 154 дүгээр зүйлийн 154.4, 154.7, 154.8 болон 154.11 дэх хэсэгт холбоотой Дүүргийн

хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооноос гаргасан тэмдэглэл шийдвэрийн тоон мэдээлэл болон уг байгууллагад ирүүлсэн нийт гомдлын тоон мэдээллийн талаар дэлгэрүүлэн судалсан.

13. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дах цахим нотлох баримтыг бэхжүүлэх, үнэлэхтэй холбоотой харьцуулсан судалгаа

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг шүүгчийн захиалгаар Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх цахим нотлох баримтыг хэрхэн бэхжүүлж, үнэлж байгаа эсэх, мөн Иргэний эрх зүйн харилцааг холбогдох хууль тогтоомжид хэрхэн зохицуулсан, мөн тусгайлсан эрх зүйн зохицуулалт байгаа эсэхийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ), Австрали Улс, Бүгд Найрамдах Эстони Улс, Бүгд Найрамдах Латви Улс (БНЛУ)-ийн хүрээнд харьцуулан судалсан.

14. Ажлын цагтай холбоотой олон улсын гэрээ, конвенц зөвлөмжийн талаарх лавлагаа

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын П.Золзаяа шүүгчийн захиалгаар Монгол Улсын нэгдэн орсон болон нэгдэн ороогүй олон улсын гэрээ, конвенц, зөвлөмжид тусгагдсан хөдөлмөрийн эрх зүйн ажлын цагийн зохицуулалтыг судалсан.

15. Гахайн сонгомол мялзан өвчний талаар монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын тухай лавлагаа

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын Н.Батзориг шүүгчийн захиалгаар Монгол Улс Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн гэрээ, конвенцид нэгдэн орсон эсэх, мөн уг гэрээ, конвенцид гахайн сонгомол мялзан өвчин (A-O5, CSF-CLASSICAL SWINE FEVER)-ий тухай хэрхэн зохицуулсан талаар Олон Улсын гэрээ, конвенцын хүрээнд судалсан.

Дээр дурдсанчлан Иргэний эрх зүйн сектор нь УДШ болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ирүүлсэн захиалгын дагуу нийт **15** судалгааг бие даан хийж гүйцэтгэсэн байна. Эдгээр 15 судалгааг төрлөөр авч үзвэл онол, харьцуулсан судалгаа – 1, харьцуулсан – 8, практик-4, практик, харьцуулсан судалгаа -1, онол, практикийн судалгаа -1 байна.

График 16. Шүүгчийн захиалгын дагуу Иргэний эрх зүйн секторын хийж гүйцэтгэсэн судалгааны төрөл



В. Бусад судалгааны жагсаалт: (захиалгын хуудасгүй хийж гүйцэтгэсэн судалгаа)

1. “Шүүхийн академи”-ийн талаарх лавлагаа

“Шүүхийн академи”-ийн талаарх ойлголтыг Турк Улс, БНСУ, Канад, ХБНГУ болон Сингапур улсын хүрээнд харьцуулан судалсан. Энэхүү судалгаанд үндэслэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнд холбогдох зохицуулалтын үндэслэл, шаардлага болон хуулийн төсөлд өгөх саналыг боловсруулсан.

2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын талаарх судалгаа

Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал болон хэвлэл мэдээллийн тухай онолын ойлголт, Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм, хүлээлгэх хариуцлага, Сэтгүүлчийн ёс зүйн дүрэмд шүүх, шүүгчид нөлөөлөх болон шүүх эрх мэдэлтэй холбоотой хүлээх хариуцлагын талаар Монгол Улс дахь 2020-2023 оны эхний хагас жил хүртэлх хэвлэл мэдээллийн байгууллагад хамаарах нөлөөллийн мэдүүлгийн тоон мэдээлэлд суурилан практик үүднээс болон ХБНГУ болон ИБУИНВУ-ын эрх зүйн зохицуулалтын хүрээнд харьцуулан судалсан. Энэхүү судалгаа нь ШССМХ-ийн цахим хуудсанд байршсан / <https://www.jtiii.mn/mn/booklist/4> /.

3.4. СЕКТОР ХООРОНДЫН ХАМТАРСАН СУДАЛГАА

Тус судалгааны төвийн секторууд нь бүх шатны шүүхийн шүүгч нараас ирүүлсэн захиалгын судалгааг салбар эрх зүйн чиглэлээр нь хариуцан, бие даан хийж гүйцэтгэдэг. Зарим тохиолдолд тухайн судалгаа нь хэд хэдэн салбар эрх зүйн шинжийг агуулсан тохиолдолд тус төвийн секторууд судалгааг хамтран хийж гүйцэтгэдэг. 2023 оны хувьд тус төвийн секторууд нь хамтран нийт 4 судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

Тус төвийн 3 сектор хамтран дараах 2 судалгааг хийж гүйцэтгэсэн.

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.8, 36.9 дэх хэсгийн хууль хэрэглээний шүүхийн практикийн судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяагийн захиалгын дагуу гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.8, 36.9 дэх хэсгийн зохицуулалтыг анхан болон давж заалдах шатны шүүхүүд хэрхэн тайлбарлаж, хэрэглэж байгаа болон Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг хүчингүй болгож буй тохиолдол байгаа эсэх, байгаа бол түүний үндэслэлийг тодруулах зорилгоор захиргааны хэргийн анхан, давж заалдах шатны 22 шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний дэг, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийг сонгосон эсхүл томилсон тогтоолыг нэг бүрчлэн судалсан.

Жич: Энэ судалгааны үр дүнд УДШ-ийн Нийт шүүгчийн хуралдааны 2023.04.14-ний өдрийн 19 дугаартай тогтоолоор баталсан “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.8, 36.9 дэх хэсгийг тайлбарлах тухай” хуулийн албан ёсны тайлбар гарсан.

2. УДШ-ийн хүлээн авч хяналтын журмаар шийдвэрлэсэн хэргийн гомдол, тогтоолд холбогдох судалгаа

Тус судалгааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Ц.Цогтын ирүүлсэн захиалгын дагуу гүйцэтгэж, МУШТХ хэрэгжиж эхэлсэн 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хооронд УДШ-ийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гаргасан гомдол, тэдгээрийг хүлээн авч хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн УДШ-ийн холбогдох Нийт шүүгчийн хуралдааны тогтоол, улмаар холбогдох маргааныг хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн УДШ-ийн тогтоол, МУШТХ-ийн төслийг хэлэлцсэн тэмдэглэл, гадаадын тодорхой зарим улсын хуулийн зохицуулалтыг дэлгэрэнгүй харьцуулан судалсан.

Тус төвийн эрүүгийн эрх зүйн сектор болон иргэний эрх зүйн сектор хамтран дараах 2 судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

- 1. Хуулийн этгээдийг эрүүгийн болон иргэний журмаар татан буулгах ажиллагааны онцлог:** УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Г.Банзрагчийн захиалгаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотойгоо судалгааг хийж гүйцэтгэсэн. Уг судалгаанд хуулийн этгээдийг эрүүгийн, иргэний журмаар татан буулгах ажиллагааны онцлогийг харьцуулан судалсны сацуу Словени, Украин, Франц, Румын зэрэг улс орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалсан.
- 2. Сэтгэл санааны хохирол, сэтгэцэд учирсан хор уршгийн талаарх судалгаа:** Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим, Эрүүгийн хэргийн танхимаас ирүүлсэн захиалгаар Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 онд батлагдсантай холбоотойгоор холбогдох салбар хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн дагуу “сэтгэл санааны хохирол” болон “сэтгэцэд учирсан хор уршиг” гэх ойлголтын агуулга, түүний харилцаа, хамаарлыг нарийвчлан судлах хэрэгцээ, шаардлага үүссэнтэй холбогдуулан Иргэний хуульд тусгагдсан “сэтгэл санааны хохирол”, Шүүх шинжилгээний тухай хуульд тусгагдсан “сэтгэцэд учирсан хор уршиг” гэх ойлголтуудын ялгаа зааг, сэтгэл санаанд учирсан хохирол, сэтгэцэд учирсан хор уршгийг бусад улсад ямар аргачлалаар хэрхэн тооцоолдог талаар дэлгэрүүлэн судалсан.


ДӨРӨВ. ШҮҮХ, ШҮҮГЧ, ОЛОН НИЙТИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

4.1. Шүүхийн шийдвэрийн хураангуй

Шүүхийн судалгааны төв нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг ил тод нээлттэй байлгах, иргэд олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэдэг бөгөөд хураангуй бэлтгэх аргачлалыг өөрчлөн, шинэчилсэн. Энэхүү шинэчилсэн аргачлал нь ШССМХ-ийн захирлын 2023 оны 04 сарын 10-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан.

Шүүхийн судалгааны төв нь 2023 онд нийт 31 шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэн олон нийтэд хүргэсэн бөгөөд 2022 онд бэлтгэн хүргэсэн 24 шүүхийн шийдвэрээс ялимгүй өссөн байна.

График 17. Өмнөх онд бэлтгэсэн шүүхийн шийдвэрийн хураангуйн тоо



Тус төв нь 2023 онд нийт 31 шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэж олон нийтэд хүргэснээс, 24 нь УДШ-ийн хяналтын тогтоол, 7 нь бусад гадаад улсын шүүхийн шийдвэрийн хураангуй байна /График 9/. УДШ-ийн хяналтын 24 тогтоолын захиргааны эрх зүйн маргаан 9, эрүүгийн хэрэг 8, иргэний эрх зүйн маргаан 7 байна. Харин гадаад улсын шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэхдээ Америкийн Нэгдсэн улс-1, Австрали-2, Оросын Холбооны улс-2, Герман -1, Канад-1 шүүхийн шийдвэрийг орчуулан хураангуйлсан байна.

График 18. ШССМХ-ээс гаргасан шүүхийн шийдвэрийн тойм, хураангуй



График 19. Хураангуйлсан шүүхийн шийдвэрийн төрөл



4.1.1. ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН СЕКТОР

Тус сектор 2023 онд **9** дотоодын шүүхийн шийдвэр, **2** гадаад улсын шүүхийн шийдвэр хураангуйлжээ.

1. Орон сууцны зориулалттай олон үл хөдлөх эд хөрөнгийг бусдад түрээслүүлж ашиг олдог бол үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлөхгүй;
2. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ авто тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас зам тээврийн осолд өртөж, өөрөө гэмтсэнийг “үйлдвэрлэлийн осол” биш гэж үзэв;
3. Аудитын байгууллага “бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний зохицуулалтыг хууль тогтоомж, гэрээний бусад заалтуудад нийцүүлэн тайлбарлаж, дүгнэлт хийснийг гэрээний чөлөөт байдлын зарчмыг алдагдуулсан гэж үзэхгүй;
4. Орой, эчнээ анги төгссөн эрх зүйчийг суралцсан хугацаа нь 4 жилээс багагүй байх шаардлагыг хангаагүй гэх үндэслэлээр хуульчийн мэргэжлийн шалгалтад бүртгэхээс татгалзсан нь үндэслэлгүй;
5. Захиргааны актын бичилтийн алдаа нь “шийтгэлийн хуудас”-ыг бүхэлд нь хүчингүй болгох үндэслэл болохгүй;
6. Хариу мессеж илгээх үнийг мэдэгдээгүйг хэрэглэгчийн “үнэ”-ийн талаар мэдээлэл авах эрхийг зөрчөөгүй гэж үзнэ;
7. Захиргааны байгууллага өөрийн алдаатай шийдвэрийн үр дүнг засан, газар ашиглах эрхийг дуусгавар болгосон нь нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгод нийцсэн;
8. Өөр бүтээгдэхүүнээр орлуулж үл болох шинжтэй бүтээгдэхүүний үнийг аж ахуй эрхлэгч үндэслэлгүй тогтоож нэмсэн бол чөлөөт зах зээлийн зарчмаар үнэ тогтоогдсон гэж үзэхгүй;
9. Зах зээлд монопол болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоогдоогүй бол аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний үнэ тогтоох үйл ажиллагаанд төрөөс зохицуулалт хийхгүй;
10. Тээврийн хэрэгслийн жолооч согтуу эсэхээ шалгуулах эрүүл мэндийн үзлэгт хамрагдах хуулийн шаардлагыг биелүүлэх ёстой (гадаад улсын шүүхийн шийдвэрийн хураангуй);
11. Танхайн сэдлийг хувийн сэдлээс ялгаж зүйлчилсэн тухай (гадаад улсын шүүхийн шийдвэрийн хураангуй).

4.1.2. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОР

Тус сектор 2023 онд нийт **11** шүүхийн шийдвэр хураангуйлснаас эрүүгийн хэргийн хяналтын шатны **8** тогтоол, гадаад улсын **3** шүүхийн шийдвэр хураангуйлжээ.

1. Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэргийг хүнийг алах гэмт хэргээс ялган зүйлчлэх нь;
2. Үргэлжилсэн хууль бус довтолгоо, халдлагын үед өөрийн боломжит үедээ хамгаалалт хийсэн нь аргагүй хамгаалалтын хүрээнд хийгдсэн үйлдэл болно;

3. Шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ гарвал түүнийг шүүгдэгчийн талд ашигтайгаар шийдвэрлэнэ;
4. Харуул хамгаалалтын ажилтан хийн буугаар буудлага хийж бусдын биед хохирол учруулсныг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцов;
5. Эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн субъектив шинж: ач холбогдол;
6. Орон сууцанд зөвшөөрөлгүй нэвтрэх нь гэмт хэрэг мөн;
7. Бусдын асран хамгаалалтад шилжүүлсэн төрсөн хүүхдийнхээ тэтгэмжийг өөртөө авсан нь гэмт хэрэг биш;
8. Хуурамч диплом ашиглан сургуульд багшилсан шүүгдэгч нийт ажилсан хугацаанд олсон орлогоо улсад буцаан төлнө;
9. Эрүүгийн хэрэгт үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байх нотолгооны стандартыг мөрдөнө (гадаад улсын шүүхийн шийдвэрийн хураангуй);
10. Нас барсан хүний орон байранд хууль бусаар нэвтэрч эд зүйл авсан нь орон байрны хулгайн гэмт хэрэг мөн (гадаад улсын шүүхийн шийдвэрийн хураангуй);
11. Цахим орчинд бусдыг заналхийлсэн захидал илгээсэн бол шүүгчийн өөрийн сэдлээс үл хамааран гэм буруутайд тооцно (гадаад улсын шүүхийн шийдвэрийн хураангуй).


4.1.3. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН СЕКТОР

Тус сектор 2023 онд **7** дотоодын шүүхийн шийдвэр, **2** гадаад улсын шүүхийн шийдвэр хураангуйлжээ.

1. Ипотекийн зээл авсан даатгуулагч нас барсан тохиолдолд даатгалын компани зээлийн төлбөрийг төлнө;
2. Хууль бусаар яллагдагчаар татагдсан, баривчлагдсан, саатуулагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан сэтгэл санааны хохирлыг төр хариуцан арилгана;
3. Үнэлгээний байгууллагаас тогтоосон хохирлын хэмжээ бодит хохирлын хэмжээнээс бага байвал зөрүү төлбөрийг хариуцагчаас гаргуулах боломжтой;
4. Компанийн эрхийг шилжүүлэх, хувьцааг худалдах-худалдан авах гэрээ байгуулж буй тохиолдолд уг хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлснээр иргэний эрх зүйн чадвартай болдог;
5. Шүүгч өндөр насны тэтгэвэрт гарахад олгогдох нэг удаагийн тэтгэмжийн хэмжээ тогтоохтой холбогдох харилцаа нь иргэний хэргийн бус захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах маргаан гэж дүгнэв;
6. Элчин сайдын яам виз олгохоос татгалзсан тохиолдолд зуучлалын байгууллага гэрээгээр тохиролцсон зөвлөх үйлчилгээний төлбөрийг зуучлуулагчид буцаан олгоно;
7. Орон сууцыг хугацаандаа ашиглалтад оруулаагүйгээс үүссэн хохиролд урьдчилгаа төлбөрийг банкны хадгаламжид хадгалсан тохиолдолд олох байсан орлогоор тооцоолон нэхэмжлэх боломжтой;
8. Аль хэдийн онлайнаар байршуулсан бүтээлийг стрийминг хийхэд хоёр биш зөвхөн нэг роялти төлөхөд л хангалттай (гадаад улсын шүүхийн шийдвэрийн хураангуй);

9. Хариуцагч шүүх хуралдаан товлогдохоос өмнө нотлох баримтыг гаргаагүйгээс үүдэн нэхэмжлэгчид гарсан зардлыг хариуцагч төлөхөөр шийдвэрлэжээ (гадаад улсын шүүхийн шийдвэрийн хураангуй).

Шүүхийн судалгааны төвөөс бэлтгэсэн шүүхийн шийдвэрийн хураангуй нь тус хүрээлэнгийн www.jtrii.mn цахим хуудас болон фэйсбүүк хуудас, legaldata.mn-ээр дамжин олон нийтэд хүрдэг билээ. Тухайлбал Эрүүгийн эрх зүйн секторын судлаачдын бэлтгэсэн хураангуй хамгийн ихдээ **80 удаа**⁴ шэйрлэгдсэн бол, Иргэний эрх зүйн секторын судлаачдын бэлтгэсэн хураангуй хамгийн ихдээ **358 удаа**⁵ шэйрлэгдэж, Захиргааны эрх зүйн секторын судлаачдын бэлтгэсэн хураангуй хамгийн ихдээ **69 удаа**⁶ шэйрлэгдсэн байна. Харин гадаад улсын шүүхийн шийдвэрийн хураангуйн тухайд Оросын холбооны улсын шүүхийн “Танхайн сэдлийг хувийн сэдлээс ялгаж зүйлчилсэн тухай” шийдвэрийн хураангуй **92 удаа**⁷ шэйрлэгдсэн байна.



⁴ “Шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ гарвал түүнийг шүүгдэгчийн талд ашигтайгаар шийдвэрлэнэ” <https://www.jtrii.mn/mn/news/126>

⁵ “Орон сууцыг хугацаандаа ашиглалтад оруулаагүйгээс үүссэн хохиролд урьдчилгаа төлбөрийг банкны хадгаламжинд хадгалсан тохиолдолд олох байсан орлогоор тооцоолон нэхэмжлэх боломжтой” <https://www.jtrii.mn/mn/news/832>

⁶ “Орой, эчнээ анги төгссөн эрх зүйчийг суралцсан хугацаа нь 4 жилээс багагүй байх шаардлагыг хангаагүй гэх үндэслэлээр хуульчийн мэргэжлийн шалгалтад бүртгэхээс татгалзсан нь үндэслэлгүй” <https://www.jtrii.mn/mn/news/136>

⁷ “Танхайн сэдлийг хувийн сэдлээс ялгаж зүйлчилсэн тухай” <https://www.jtrii.mn/mn/news/144>

Мэдээлийн төв

		ЯЛТАН Б.МАХБАЛД ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНААС ӨМНӨ СУЛЛАЖ ХЯНАЛТ ТОГТООСОН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОВ Orgilmaa 2023-12-08
		Ц.ХУЛАН, Б.ОТГОНБААТАР НАРТ ХОЛБОГДОХ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР Orgilmaa 2023-12-08
		ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛАХГҮЙГЭЭР ТӨНССЭН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ, ХҮЛЭЭЛГЭСЭН ҮҮРГИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТААС ЗАЙЛСХИЙСЭН ЯЛТНЫ ХОРИХ ЯЛЫГ БИЕЧЛЭН ЭДЛҮҮЛЭХЭЭР ШИЙДВЭРЛЭЖЭЭ Orgilmaa 2023-12-08

Үүнээс гадна нийт 117 шүүхийн сайтад байршсан шүүхийн шийдвэрийн тоймыг түүвэрлэж, хүрээлэнгийн www.jtrii.mn сайтад шүүхийн шийдвэрийн хураангуй болон тоймыг нэг дороос үзэх боломжтой байдлаар байршуулсан.



Шүүгч, шүүх бүрэлдэхүүн гаргасан шийдвэрээ ойлгомжтой байдлаар цаг тухайд нь олон нийтэд “ТОЙМ”-лон хүргэнэ.

Шүүгч, шүүх бүрэлдэхүүний гаргасан шийдвэрийн хуулийн үндэслэл болон хэргийн үйл баримтыг хэрхэн тайлбарлан хэрэглэснийг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаачид олон нийт, эрх зүйн чиглэлээр суралцагч, хуульч, судлаачдад зориулан “ХУРААНГУЙ”-лан хүргэнэ.



www.jtrii.mn



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТОЙМ, ХУРААНГУЙГ НЭГ ДОРООС

4.2. Олон нийтийг мэдээллээр хангах, чиг үүргийн хүрээнд

Хүрээлэнгийн чиг үүрэг, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд мэдээлэх, нийтлэх бусад төв нэгжүүдийн үйл ажиллагааг сурталчлах хүрээнд өдөр тутмын үйл ажиллагааг тогтмол мэдээлэх байдлыг хэвшүүлсэн. Энэ хүрээнд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Мэдээллийн төв 2023 онд цаг үеийн 75 мэдээ мэдээлэл бэлтгэн түгээсэн. Үүнээс нь 11 мэдээг Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд 5 мэдээг хөдөлгөөнт хэлбэрээр бэлтгэн түгээсэн байна. Эдгээр мэдээнүүд сургалтын мэдээ, уулзалтын мэдээ, зар мэдээ, бусад гэсэн төрлүүдэд ангилагдаж байна. Мөн гадаад улсын байгууллагатай хамтран ажилласан мэдээ мэдээллүүд англи хэл дээр орчуулагдан цахим хаягуудаар түгээгдсэн болно.

Мэдээллийн төвөөс сар бүр “Мэдээллийн товхимол” гаргаж хэвшсэн ба энэ нь тухайн сарын хугацааны мэдээг тоймлон бэлтгэж бүх шатны шүүгч нарт сар бүрийн сүүлийн өдөр и-мэйл хаягаар нь илгээж байна.



Мөн Хүрээлэнгийн ажиллах журмын 6.1.7–т *Шүүхийн сургалтын видео материал, цахим подкаст, ярилцлага бэлтгэх, шүүхийн талаарх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх мэдээ, нэвтрүүлэг бэлтгэх, түгээх студи ажиллуулах чиг үүргийн хүрээнд нийт 68 контент бэлтгэсэн бөгөөд мэтгэлцэх ур чадварын сургалтын видео контент бүтээсэн нь энэ жилийн онцлох ажлын нэг байсан.*



Эрүүгийн хэргийн шүүхийн шүүгчдэд зориулсан “Мэтгэлцэх ур чадвар” видео контент бүтээх

Азийн сан, Ханнс-Зайделийн сангийн дэмжлэгтэйгээр Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн, Монголын Хуульчдын холбоотой хамтран шүүгч, прокурор, өмгөөлөгч, хуульчдын хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, жишиг тогтоох зорилгоор сургалтын контент бүтлээ.

Хамтарсан баг контент бүтээх ажлыг 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлсэн бөгөөд уг ажил 10 сарын турш үргэлжилсэн юм.

Өмнө нь энэ төрлийн контентыг 2004 болон 2009 онд хийж, шүүгчийн сургалтад ашиглаж байжээ. Энэ удаагийн контентын ахлах зөвлөхөөр УДШ-ийн шүүгч Б.Батцэрэн ажиллаж, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 5 шүүгч 6 төрлийн процесс ажиллагааг илэрхийлсэн контентод дүр бүтээн оролцлоо.




Тус контентын гол онцлог нь хохирогч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, шүүгдэгч, гэрчид мэргэжлийн жүжигчид, бусад дүрд дүрийнхээ ажлыг бодитоор хийдэг мэргэжлийн хүмүүс оролцсон явдал байлаа. Контентын зураг авалтыг Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн

анхан шатны шүүх, ЦЕГ-ын мөрдөн байцаах хэлтсийн хүүхдийн мэдүүлгийн өрөө, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба байранд хийсэн. Сургалтын контентыг бүтээхэд нийт 39 албан хаагч оролцсон.

Сургалтын контент нь дараах 6 хэсгээс бүрдэнэ:

- Таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн анхны хэлэлцүүлэг – 28м31с;
- Таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх шүүхийн хэлэлцүүлэг – 18м45с;
- Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг – 17м42с;
- Шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан шийдвэрлэх үндсэн шүүх хуралдаан – 1ц27м07с;
- Шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан шийдвэрлэх үндсэн шүүх хуралдаан (Эрүүгийн хуулийн 10.6 дугаар зүйл) – 1ц22м34с;
- Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх шүүх хуралдаан 16м27с.

Үүнээс гадна сургалтын төв, судалгааны төв нь Сургалтын хөтөлбөрийн хорооны хуралдаан болон хуралдаанаас гарсан шийдвэрийн талаар, Шүүгчийн сургалтын зар болон бусад зохион байгуулалтын талаарх мэдээллийг Хүрээлэнгийн Мэдээллийн төвтэй хамтран нийтэд хүргэж ажиллаж байгаа бол шүүгчийн сургалтын багц цаг, сургалтад баримтлах дүрэм, журам, цахим сургалтын талаарх мэдээллийг



Сургалтын цахим системээр дамжуулан шүүгчдэд хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



*УДШ-ээс гаргасан тайлбар
дагасан сургалт (орон нутгийн
шүүхүүд)*

Ерөнхий шүүгч, болон УДШ-ийн танхимуудаас орон нутгийн шүүхийн шүүгчидтэй уулзаж УДШ-ээс гаргаж буй тайлбартай холбоотой мэдээллийг хүргэх зорилготой сургалт, семинарыг 2023 оны 6 дугаар сарын 9-ний өдөр Өвөрхангай аймгийн Хархорин суманд зохион байгуулсан.


Уг үйл ажиллагаанд Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүхийн 32 шүүгч оролцсон.



График 20. ШССМХ-ийн Мэдээллийн төвөөс гаргасан мэдээ, мэдээлэл



График 21. ШССМХ-ийн Мэдээллийн төвөөс гаргасан мэдээний төрөл



4.3. Хэвлэн, нийтлэх чиг үүргийн хүрээнд

Иргэний хэргийн шүүхийн шүүгчдийн 2022 оны сургалтын гарын авлага боловсруулах, хэвлүүлэх, түгээх



Шүүгч багш нарын боловсруулан ирүүлсэн бодлого, онолын ойлголтын талаарх материалыг нэгтгэн, гарын авлагын эхийг бэлтгэн ГОУХАН-д хүргүүлэв.

Номын өрөлт хийгдсэний дараа эхийг редакторлуулан 2023 оны 5 дугаар сард хэвлэлтэд шилжүүлэн 5 дугаар сарын 31-ний өдөр 500 хувь номыг хүлээн авч, иргэний хэргийн шүүхийн шүүгчид болон хууль зүйн их дээд сургуулийн номын сан, судалгаа шинжилгээний байгууллага болон холбогдох бусад байгууллагад түгээв.

ҮХЭЗ-н Хүрээлэнгийн “НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар, сургалтын хөтөлбөр” сэдэвт гарын авлагыг хэвлүүлэх, түгээх



Шүүгч заавал судлах 2023 оны Үндсэн хуулийн эрх зүйн чиглэлийн сургалтыг МУИС-ийн Үндсэн хуулийн хүрээлэнгээс эрхлэн гаргасан НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар болон сургалтын хөтөлбөр бүхий “Үндсэн хууль—манай сургуульд” номын агуулгаар хүргэхээр Сургалтын хөтөлбөрийн хорооноос шийдвэрлэсэн. Энэ дагуу Шүүхийн сургалтын төвөөс гарын авлага хэвлүүлэх бэлтгэл ажлыг хангаж ҮХЭЗ-н Хүрээлэнтэй гэрээ байгуулж тус номыг 500 хувь хэвлүүлж хүлээн авсан.

2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Нийт шүүгчдийн хоёрдугаар чуулган”-ны үеэр нийслэл болон орон нутгийн нийт 381 шүүгчид “номыг тарааж ажилласан бол үлдсэн шүүгчид танхимын сургалт зохион байгуулах үеэр түгээв.

Иргэний хэргийн шүүхийн шүүгчдийн 2023 оны сургалтын гарын авлага боловсруулах, хэвлүүлэх, түгээх



Шүүгч багш нарын боловсруулан ирүүлсэн бодлого, онолын ойлголтын талаарх материалыг нэгтгэн, гарын авлагын эхийг бэлтгэн ГОУХАН-д хүргүүлэв.


Номын өрөлт хийгдсэний дараа эхийг редакторлуулан 2023 оны 10 дугаар сард хэвлэлтэд шилжүүлэн 10 дугаар сарын 24-ний өдөр 500 хувь номыг хүлээн авч, иргэний хэргийн шүүхийн шүүгчид болон хууль зүйн их дээд сургуулийн номын сан, судалгаа шинжилгээний байгууллага болон холбогдох бусад байгууллагад түгээв.

Шүүхийн шийдвэрийн тойм номыг түгээх



Шүүхийн шийдвэр тойм (2022) эмхэтгэлийг нийслэл, орон нутгийн анхан шатны нийт шүүхэд түгээх ажлыг зохион байгуулсан.


Иргэний хэргийн шүүхийн шүүгчийн сургалтын гарын авлагын эмхэтгэл номыг түгээх



Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, УДШ-ийн Иргэний хэргийн танхим, шүүгч сургагч-багш нар хамтран Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр Иргэний хэргийн шүүхийн шүүгчийн сургалтад зориулан 2002 оноос хойш хэвлэгдсэн 20 орчим гарын авлагыг нэгтгэн, шинэчлэн сайжруулж, эмхэтгэл болгон хэвлүүлснийг нийслэл, орон нутгийн нийт шүүгчдэд түгээх ажлыг зохион байгуулсан.

Мөн 2023 онд Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчдэд уг эмхэтгэлийг түгээх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

“Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны эрх зүй: Онол, хэрэглээ, тулгамдсан асуудал” сэдэвт номыг түгээх



Шүүхийн сургалт, судалгаа, хүрээлэнгийн Шүүхийн судалгааны төвийн дарга Б.Дөлгөөний “Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны эрх зүй: Онол, хэрэглээ, тулгамдсан асуудал” бүтээлийг Захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн мэргэшүүлэх сургалтын үеэр түгээв.

“Монгол Улсын иргэний хуулийн тайлбар” сэдэвт номыг түгээх



“Монгол Улсын иргэний хуулийн тайлбар: Гэрээний бус үүрэг” номыг 2017 оноос хойш томилогдсон шүүгчдэд Иргэний хэргийн шүүхийн шүүгчдийн мэргэшүүлэх сургалтын үеэр түгээв.


ТАВ. “МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ СЭТГҮҮЛ” ЭРХЛЭН ГАРГАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

УДШ-ээс 1995 оноос тасралтгүй эрхлэн гаргаж буй улирал тутмын, мэргэжлийн эрдэм шинжилгээний “Монголын төр, эрх зүй” сэтгүүлийг хариуцах чиг үүрэг УДШ-ийн Ерөнхий шүүгчийн 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 36 дугаар захирамжаар Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Шүүхийн судалгааны төвд шилжсэн.

Энэхүү чиг үүргийн хүрээнд 2023 оны 3 сард сэтгүүлийн №103, 5 сард №104, 10 сард №105 дугааруудыг эрхлэн гаргасан бөгөөд одоогоор сэтгүүлийн №106 дугаарыг гаргахаар бэлтгэж байна. Сэтгүүлийн №103 дугаарт нийт **5**, №104 дугаарт нийт **8**, №105 дугаарт нийт **7** эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгаа, орчуулга нийтлэгдэж олон нийтэд хүрсэн байна.

ЗУРГАА. ШҮҮГЧИЙН СУРГАЛТЫН ЦАХИМ СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭЛТ

Шүүхийн сургалтын төв нь “Эрин системс”-тэй хамтран 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн “Шүүгчийн сургалтын цахим систем”-ийн хөгжүүлэлтийг хийж эхэлсэн.




Гүйцэтгэгчтэй тохиролцсон төлөвлөгөөний дагуу сар бүр 1-3 удаагийн уулзалт зохион байгуулж, хийж гүйцэтгэж буй ажлын явц, үр дүн, цаашид хийх ажлын төлөвлөгөө, уулзалтаас гарсан асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж байна. Нийт 18 удаагийн уулзалтын үр дүнд хэрэглэгчийн эрхийн матрицын дагуу “групп тохиргоо, хэрэглэгчийн тохиргоо, сургалтын нэгдсэн календарь, хэрэглэгчийн профайл, онлайн сургалт,

танхимын сургалт, үнэлгээ, хяналтын самбар, тайлан, вебинар” цэсийг үүсгэж, 12 сарын хугацаанд 5 удаагийн томоохон туршилт, шинэчлэлийг хийж ажилласан.

- Сургалтын системийн эхний хувилбарыг турших (1 сар);
- Сургалтын системд шүүгчдийг бүртгэх (2-3 сар);
- Системийн эхний хэсгийг хэрэглээнд нэвтрүүлэх (2-3 сар);
- Системд 2 дахь шинэчлэлт хийх, турших (3-4 сар);
- Системд 3 дахь шинэчлэлт хийх, турших (5-6 сар);
- Системийг хүлээн авах (5-6 сар);
- Цаашид хөгжүүлэх модуль болон хэрхэн хамтран ажиллах талаар харилцан тохирох (6 сар);
- Системийн шинэ модулийн хөгжүүлэлт “Менторшип” (7-10 сар);
- Системд 4 дэх шинэчлэлт хийх, турших (7 сар);
- Системийн тайлангийн хөгжүүлэлт (10-11 сар);
- Системд 5 дахь шинэчлэлт хийх, турших (12 сар).

Шинээр орсон хөгжүүлэлтийг хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор туршилтуудыг хийж, илэрсэн алдаа дутагдлыг гүйцэтгэгчид тухай бүр хэлж, сайжруулалтыг хийж ажиллаж байна.

Шүүгчийн сургалтын цахим системд нийт 507 шүүгч (үүнээс эрэгтэй 202, эмэгтэй 305), 15 судлаач, ШЕЗ-ийн 1 гишүүн бүртгэж, 55 видео хичээл, системийн гарын авлага 13-ыг байршуулсан. Шүүгчийн сургалтын цахим системийг шүүгчдэд идэвхтэй ашиглуулахын тулд системд нэвтрэх зааварчилгааг утсаар болон




цахим шуудангаар өгч ажиллаа. Түүнчлэн энэхүү цахим системээр дамжуулан багц цагийг тооцож эхэлсэн бөгөөд 2022 оны багц цагаа хангасан 375 шүүгчид батламжийг олгосон байна.⁸

Системд “Вебинар, Менторшип, Цахим номын сан” модулийг шинээр хөгжүүлж, нэвтрүүлсэн нь нь бусад системээс ялгарах гол онцлог юм. Цаашид системийн хөгжүүлэлтийн ажил үргэлжлэх бөгөөд тухайн жилийн шүүгчийн сургалтын багц цагийг автоматаар тооцон, батламж олгох үйлдлийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Системд “Цахим номын сан” цэсийг шинээр үүсгэсэн бөгөөд шүүгчид Шүүхийн судалгааны төвийн судалгаа, Монголын төр, эрх зүй сэтгүүл, сургалтын тайлан, гарын авлагуудтай танилцах бүрэн боломжтой болсон. Системийн “Цахим номын сан”-д ШССМХ-ээс эрхлэн гаргаж буй дараах бүтээлүүд байршиж байна:


Цахим хичээл - 50

Цахим хичээлийг 9 ангилан нийт 50 сургалтыг байршуулсан бөгөөд суралцагчид хүссэн газраасаа цаг хугацааг үл харгалзан хичээлээ үзэж судлан багц цагаа хангах боломжтой болсон.




⁸ 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар.


Судалгаа – 25



Монголын төр, эрх зүй сэтгүүл – 5



Сургалтын гарын авлага – 6



Сургалтын тайлан – 26

ЦАХИМ НОМЫН САН		Бүтээлийн ангилал	СУРГАЛТЫН ТАЙЛАН – 2023 ОН	Бүтээл нэмэх
	"ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ТӨВТЭЙ, ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА" СЭДЭВТ СУРГАЛТЫН ТАЙЛАН - 2023	2023-12-05	ШССМХ-ийн Сургалтын төв	
	"Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хянан шийдвэрлэх ажиллагаа" сэдэвт сургалт – сонгон судлах 0.5 багц цаг			
	"ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ" СЭДЭВТ СУРГАЛТЫН ТАЙЛАН - 2023	2023-10-17	ШҮҮХИЙН СУРГАЛТЫН ТӨВ	
	"Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт" сэдэвт сургалт – сонгон судлах 0.5 багц цаг			
	ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТАЙЛАН - 2023	2023-10-17	ШҮҮХИЙН СУРГАЛТЫН ТӨВ	
	Захиргааны хэргийн давж заалдах болон анхан шатны шүүхийн шүүгчдийн мэргэшүүлэх сургалт – заавал судлах 2 багц цаг			
	НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН ДҮҮРГИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТАЙЛАН - 2023	2023-10-17	ШҮҮХИЙН СУРГАЛТЫН ТӨВ	
	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах болон дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн мэргэшүүлэх сургалт – заавал судлах 2 багц цаг			
	АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД ШИНЭЭР ТОМИЛОГДСОН ШҮҮГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭН ДАДЛАГАЖУУЛАХ СУРГАЛТЫН ТАЙЛАН - 2023	2023-06-14	ШҮҮХИЙН СУРГАЛТЫН ТӨВ	

ДОЛОО. ХҮРЭЭЛЭНТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ШҮҮГЧ НАР

7.1. Шүүгч-судлаач

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Зөвлөгөөн болон шүүгчийн өөрийнх нь саналыг үндэслэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг зургаан сар хүртэл хугацаагаар Хүрээлэнд судлаачаар ажиллуулж болох бөгөөд түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгож, шүүгчээр ажилласанд тооцно.” гэж заасан. ШССМХ-ийн ажиллах журамд заасны дагуу 2023 онд шүүгч-судлаачаар ажиллах хүсэлтээ ирүүлсэн шүүгчдээс дараах **дөрвөн шүүгч** сонгогдон тус бүр зургаан сарын хугацаанд шүүгч-судлаачаар ажилласан /Хавсралт 1/.

1. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ж.Оюунтунгалаг 2023.02.06-ны өдрөөс эхлэн 2023.08.06-ны өдөр хүртэл;
2. Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Отгонтуяа нь 2023.02.06-ны өдрөөс эхлэн 2023.08.06-ны өдөр хүртэл;
3. Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Батааг 2023.03.01-ны өдрөөс эхлэн 2023.09.01-ны өдөр хүртэл;
4. Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Володяг 2023.03.01-ны өдрөөс эхлэн 2023.09.01-ны өдөр хүртэл.

ШССМХ-ийн захирал нь “Шүүгч-судлаачийн ажлын удирдамж батлах тухай” 2023 оны 04 сарын 19-ны өдрийн А/09 дүгээр тушаалыг гаргасан бөгөөд энэхүү тушаал нь шүүгч-судлаач Хүрээлэнд ажиллах хугацаандаа удирдлага болгох зарчим болон хийж гүйцэтгэх ажлыг тодорхой болгох, тус харилцаанд Хүрээлэн болон шүүгч-судлаачийн хариуцах ажил үүргийг нарийвчлан тогтоох зорилготой юм. Тус төв нь 2023 оны шүүгч-судлаач нарын хийж гүйцэтгэсэн нийт 8 судалгааг **“Шүүгч-судлаач: Судалгааны ажлын эмхэтгэл” Цуврал 1** болгон хэвлэн, олон нийтэд хүргээд байна.



7.2. Шүүгч-сургагч багш нар

Шүүгч сургагч багшийн сонгон шалгаруулалтыг зарлан, шалгуур хангасан сургагч багшаар ажиллах хүсэлтэй 9 шүүгчийн хүсэлтийг хүлээн авч, сургагч багшийн бүртгэлийг шинэчлэв. ШССМХ-д эрүүгийн 16, иргэний 14, захиргааны 8, нийт 38 сургагч багш бүртгэлтэй байна. /Хавсралт 3/




НАЙМ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд нийт 5 хамтран ажиллах санамж бичиг байгуулж, шүүх эрх мэдлийн хүрээнд хамтран ажилладаг 8 улс руу 75 шүүгч, судлаач (давхардсан тоогоор) айлчилж, туршлага судалсан байна.

Хүснэгт 12. 2023 онд айлчлал хийсэн улсууд



График 23. 2022 болон 2023 онд хийсэн гадаад улсын төлөөлөлтэй хийсэн уулзалтын тоон харьцуулалт



Шүүх эрх мэдлийн хүрээнд хамтран ажилладаг олон улсын байгууллагуудтай уулзалт зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн:

3.1. Хамтын ажиллагааны санамж бичиг

Хамтын ажиллагааны хүрээнд 2023 онд нийт 5 хамтран ажиллах, санамж бичиг байгуулсан. Үүнд:

1. Монгол Улсын Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн болон Бүгд Найрамдах Турк Улсын Шүүхийн Академи хоорондын шүүгч, нэр дэвшигч/шүүгчийн туслахыг сургахтай холбоотой хамтын ажиллагаанд хамаарах харилцан ойлголцлын санамж бичиг;
2. Дэлхийн оюуны өмчийн байгууллага болон Монгол Улсын Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн хоорондын хамтын ажиллагааны гэрээ;
3. Дэлхийн оюуны өмчийн байгууллага болон Монгол Улсын Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;

4. Дэлхийн оюуны өмчийн байгууллага болон Монгол Улсын Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн хоорондын “дэлхийн оюуны өмчийн байгууллагын хууль эрх зүй – шүүхийн шийдвэрийн сан”-д хамаарах харилцан ойлголцлын санамж бичиг,
5. Нагояа их сургуулийн Азийн эрх зүйн солилцооны төв болон Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг

3.2. Гадаад айлчлал

1.Хууль хяналтын байгууллагын төлөөлөгчид БНАЛАУ-д зочилж туршлагаа хуваалцлаа.

2023 оны 2 дугаар сарын 6-наас 11-ний өдрүүдэд БНАЛАУ-ын Вьентьян хотноо болсон тус айлчлалд Монгол Улсын дээд шүүх, Чингэлтэй дүүргийн анхан шатны шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, Монголын Хуульчдын Холбоо, МУИС-ХЗС, Азийн Сангийн төлөөлөгчдөөс бүрдсэн 14 хүний бүрэлдэхүүнтэй баг тус айлчлалд оролцсон.

Айлчлалын хөтөлбөрт тус улсын Прокурорын байгууллага, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Ардын дээд шүүх, Ардын дээд шүүхийн дэргэдэх Судалгаа, сургалтын хүрээлэн, Хуульчдын холбоо зэрэг байгууллагуудад зочлох үеэр шүүгч, прокурор, хуульчдын дунд хэрэгжүүлсэн менторшип хөтөлбөрийн талаарх сайн туршлагыг танилцууллаа.



2. Монгол Улсын шүүгч нар олон улсын сургалтад хамрагдлаа.



Монгол Улсын дээд шүүхийн шүүгч М.Батсуурь, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Батаа нар 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөс 17-ны өдрүүдэд Тайланд Улсын нийслэл Бангкок хотноо болсон шүүгч, прокуроруудад зориулсан сургалтад хамрагдлаа. Сургалтыг Олон улсын хууль сахиулагчийн академи/ ILEA-BANGKOK /-аас “Цахим нотлох баримт”-сэдвээр зохион байгуулжээ

3. Монгол Улсын дээд шүүхийн шүүгч нар ХБНГУ-д зочилж, туршлага солилцлоо.

Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, шүүгч Ц.Цогт, Г.Банзрагч, Д.Батбаатар нар Монгол Улс дахь Ханнс Зайделийн сангийн урилгаар 2023 оны 6 дугаар сарын 19-26-ны өдрүүдэд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн практик хэрэглээ, түүний нэгдмэл байдлыг хангах арга механизм, хууль тайлбарлан хэрэглэх практик, түүнд ХБНГУ-ын дагнасан хэвлэлийн байгууллагуудын үүрэг оролцоо, шүүхийн цахимжуулалтын бодлого, улс төрийн намын бүртгэл сэдэвт туршлага солилцох айлчлалд оролцлоо.

4. Ази, номхон далайн бүсийн шүүхийн 5 дахь удаагийн дээд хэмжээний уулзалтад монгол улсаас хоёр шүүгч оролцлоо.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрхийн комиссын Ази, Номхон далайн бүсийн төв (UNCITRAL RCAP)-тэй хамтын ажиллагааны хүрээнд Хонконг улсад 2023 оны 11 дүгээр сарын 6, 7-ны өдрүүдэд НҮБ-ын Олон улсын худалдааны эрхийн комиссын Ази, Номхон далайн бүсийн Шүүхийн 5 дахь удаагийн дээд хэмжээний уулзалт зохион байгуулсан юм.

Энэхүү дээд хэмжээний уулзалтад Монгол Улсыг төлөөлөн Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Азбаяр, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.Мөнхтулга нар оролцож, туршлага судаллаа.



5. Бүгд Найрамдах Турк улсын шүүхийн академитай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

Монгол Улсын Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн 2023 оны 11 сарын 13-ны өдөр Бүгд найрамдах Турк Улсын Шүүхийн Академитай харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.



Уг санамж бичгийн хүрээнд талууд шүүгчийн танхимын болон цахим сургалт зохион байгуулах, хамтарсан судалгаа хийх, олон улсын хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр хамтран ажиллахаар тохиров. Монголын улсын дээд шүүхийн шүүгч М.Батсуурь, Д.Батбаатар, хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар Анкара хот дахь Шүүхийн Академийн байранд

зочилж, хоёр талын уулзалт хийв. Уулзалтын үеэр талууд хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар тохиролцсон санамж бичгийг байгуулсан бөгөөд шүүгч М.Батсуурь энэ санамж бичиг нь хоёр талын шүүхийн харилцаа, хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэж, Монголын шүүгч нарт оюуны том хөрөнгө оруулалт болно гэдэгт итгэж буйгаа илэрхийлсэн.

Бүгд Найрамдах Турк Улсын Шүүхийн Академи нь 2003 онд байгуулагдан шүүгч, прокурор, шүүгч, прокурорт нэр дэвшигч, хуульч, өмгөөлөгчдөд зориулсан бүх төрлийн сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй ажилладаг байна. Мөн тус Академи нь гадаадын 72 улсын шүүхийн хүрээлэнтэй хамтран ажиллаж байгаагаас 47 улсын хүрээлэнтэй албан ёсны хамтын ажиллагааны гэрээ байгуулжээ.

6. Дэлхийн оюуны өмчийн байгууллагын шүүхийн хүрээлэнтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулав.

Монгол Улсын дээд шүүхийн шүүгч М.Батсуурь, Д.Батбаатар тэргүүтэй төлөөлөгчид 2023 оны 11 дүгээр сарын 14-17-ны өдрүүдэд Швейцарын Холбооны Улсын Женев хотод ажиллах үеэрээ Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДООБ)-ын Шүүхийн хүрээлэнг хариуцсан Орлогч захирал Марко Алемантай хоёр талын уулзалт хийж, хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах ажиллагаанд оролцов.



Монгол Улсын Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн болон ДООБ-ын Шүүхийн хүрээлэн уг хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын шүүгчдэд оюуны өмчийн мэдлэг олгох, шүүгчдийн чадавхыг дээшлүүлэх, оюуны өмчид хамаарах шүүхийн шийдвэрийг нэгтгэн ДООБ-ын мэдээллийн санд байршуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар тохирлоо.

7. Монгол Улсын 30 шүүгч Бүгд Найрамдах Турк улсад айлчилж, сургалтад хамрагдлаа.

2023 оны 12 дугаар сарын 11-16-ны өдрүүдэд Монгол Улсаас нийт 30 шүүгч Бүгд найрамдах Турк Улсын Шүүхийн Академид зочилж, танхимын сургалтад хамрагдлаа.



Энэхүү сургалт нь Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Бүгд найрамдах Турк Улсын Шүүхийн Академитай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсны хүрээнд хэрэгжиж буй хамтын ажиллагааны эхлэл болов. Санамж бичгийн хүрээнд талууд шүүгчийн танхимын болон цахим сургалт зохион байгуулах, хамтарсан судалгаа хийх,

олон улсын хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр хамтран ажиллахаар тохиролцсон бөгөөд энэхүү ажлууд нь цаашид шат дараатай хэрэгжих юм.

Сургалт “Шүүх болон дагнасан шүүхүүдийн удирдлага зохион байгуулалт” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан ба “БНТУ-ын Шүүхийн Академийн үйл ажиллагаа”, “БНТУ-ын Шүүхийн тогтолцоо”, “Хүнд төрлийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх”, “Гэр бүлийн шүүх”, “Арилжааны анхан шатны шүүх”, “Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх шүүх”, “Насанд хүрээгүйчүүдийн шүүх”, “Хохирогчдын эрхийг хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа” болон “Үндэсний шүүхийн сүлжээ төсөл, дуу дүрсний мэдээллийн систем”, “Шинжээчийн үйл ажиллагаа” зэрэг дэд сэдвүүд сургалтын хөтөлбөрт багтжээ.




8. Сингапур улсын шүүхийн коллежийн үйл ажиллагаатай танилцлаа.

Хүрээлэнгийн Судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн (Ph.D), тус төвийн Эрүүгийн эрх зүйн секторын эрхлэгч О.Инжиннаш, Улсын дээд шүүхийн Практик судлалын хэлтсийн дарга М.Хатанзориг (Ph.D) болон Дээд шүүхийн захиргааны ажилчид 2023 оны 12 сарын 14,15-ны өдрүүдэд Сингапур улсын Дээд шүүхээр зочилж, тус улсын Шүүхийн коллежийн гүйцэтгэх захирал Пол Куан (Paul Quan)-тай уулзлаа.



Хүрээлэнгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж болохуйц сайн туршлага солилцсон байна.

9. БНСУ-д зохион байгуулагдсан олон улсын бага хуралд хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг оролцлоо.



Бүгд Найрамдах Солонгос Улсын Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнгээс 2023 оны 11 дүгээр сарын 28-наас 30-ны өдрүүдэд “Парадигмын өөрчлөлт ба шүүхийн хариу арга хэмжээ – хиймэл оюун ухаанаас үүдэлтэй хууль зүйн асуудлууд ба шүүхийн ирээдүй, уур амьсгалын өөрчлөлт ба шүүхийн маргаан” сэдэвт олон улсын бага хуралд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг илтгэл хэлэлцүүлэв.

10. Иргэний хэргийн сургагч багш нар ХБНГУ-д айлчлал хийж, туршлага солилцов.

2023 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс 12 дугаар сарын 03-ны өдрүүдэд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр Иргэний хэргийн 15 сургагч багш нар ХБНГУ-д айлчлал хийж, Германы шүүхийн тогтолцоотой танилцаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн онцлогийн талаар санал солилцсон бөгөөд Бавари мужийн шүүгчийн сургалтад хамрагдсан байна.

3.3. ШССМХ-д зочилсон гадаад улсын төлөөлөл

1. Франц улсын их сургуулийн дадлагажигч шүүгчийг хүлээн авч уулзлаа.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг /Хууль зүйн доктор, дэд профессор/ Бүгд Найрамдах Франц улсын Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яамны Тэргүүн зөвлөх Жулиен Пауперт, тус улсын Шүүхийн Их Сургууль /ENM - École Nationale De La Magistrature/-ийн дадлагажигч шүүгч, эрх зүйч Эстэнбан Грандин-Мартин болон орчуулагч Ж.Насанжаргал нарыг хүлээн авч уулзлаа.



Уулзалтын үеэр дадлагажигч шүүгч Эстэнбан Грандин-Мартины Монгол Улсын хууль эрх зүйн сургалтын тогтолцоо үе шат, тэр дундаа шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн сургалтын талаар сонирхсон асуултуудад хариулт өгч хүрээлэнгээс зохион байгуулдаг шүүгчийн сургалтын онцлогийг танилцуулж мэдээлэл солилцлоо.

2. Япон улсын Нагояагийн их сургуулийн төлөөлөлтэй уулзлаа.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Япон улсын Нагояагийн Их Сургуультай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүрээнд мэдээлэл солилцлоо.



Уулзалтад Нагояагийн их сургуулийн “Азийн эрх зүйн солилцооны төв”-ийн захирал хадагтай Масako Мураками /Masako Murakami/ Доктор, профессор// болон Окочи Минорү /Okochi Minori / профессор /, Фүмито Сато /Fumito Sato/ профессор// нар оролцлоо.

4. Оюуны өмчийн чиглэлээр сургалт зохион байгуулна.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д. Эрдэнэчимэг, Сургалтын төвийн дарга Г. Халиунаа нар Монгол Улсад оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийн чиглэлээр сургалт зохион байгуулах сургагч багш нарыг 2023 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр хүлээн авч уулзав.



ажилтан Марк Абумери, АНУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны Худалдааны хэлтсийн ажилтан М.Алтанцэцэг нар оролцов.

Уулзалтад АНУ-ын Флорида мужийн Төв дүүргийн шүүхийн шүүгч Виржиниа Ковингтон, Хойд дүүргийн шүүхийн шүүгч Майкл Ж.Франк, АНУ-ын Хууль Зүйн Яамны Оюуны өмч, кибер аюулгүй байдлын асуудал хариуцсан зөвлөх Жеймс Юүн, АНУ-ын Патент, Барааны Тэмдгийн Газрын Гадаад харилцаа, бодлогын газрын Хуулийн хэрэгжилтийн хэлтсийн

Уулзалтын эхэнд оюуны өмчийн чиглэлээр хоёр улсын шүүгчид оюуны өмчид хамаарах хэрэг маргаан шийдвэрлэх туршлага солилцох боломжийг олгож, сургалт зохион байгуулан ажиллаж байгаад талархал илэрхийлсэн бөгөөд энэ сарын 13-ны өдөр зохион байгуулагдах уламжлалт “Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт” сэдэвт сургалтын зохион байгуулалтын асуудлаар хэлэлцэж, хоёр улсын оюуны өмчийн хэрэг маргаан шийдвэрлэлтийн онцлогийн талаар санал солилцлоо.

ЕС. БУСАД

9.1. Журмын төсөл бэлтгэх ажлын хүрээнд

1. Судалгааны төв нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг ил тод нээлттэй байлгах, иргэд олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэдэг бөгөөд хураангуй бэлтгэх **аргачлалыг өөрчлөн, шинэчилсэн**. Энэхүү шинэчилсэн аргачлал нь ШССМХ-ийн захирлын 2023 оны 04 сарын 10-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан.
2. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс эрхлэн гүйцэтгэж буй бүх төрлийн судалгааны бүтээлүүдэд болон Монголын төр, эрх зүй сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авахад мөрдөж хэрэгжүүлэхээр **“Эшлэл хийх, эх сурвалжийг заах, ном зүйн бичилт хийх стандарт”**-ыг гаргасан бөгөөд тус стандартыг Хүрээлэнгийн захирал 2023 оны 05 сарын 18-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар баталсан.
3. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт зааснаар тус судалгааны төвд шүүгч судлаач ажиллаж, судалгаа хийх боломжтой юм. Судалгааны төвөөс **“Шүүгч-судлаачийн ажлын удирдамж”**-ыг гаргасан бөгөөд тус удирдамж нь Хүрээлэнгийн захирлын 2023 оны 04 сарын 19-ны өдрийн А/09 дугаар тушаалаар батлагдсан.



ШСММХ-ийн 2024 оны төсвийн төсөлд тухайн онд зохион байгуулах шүүгчийн сургалт болон Шүүхийн сургалтын төвд шаардагдах тоног, төхөөрөмж, холбогдох бусад зардлын тооцооллыг хийн, төслийг танилцуулгын хамт бэлтгэн удирдлагад хүргүүлсэн.

- Улсын дээд шүүхийн стратеги төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний саналыг холбогдох хууль, дүрэм, журам, бодлогын баримт бичгийг судалж хүрээлэнд хамаарах зорилго, зорилтын хүрээнд боловсруулсан.
- БНСУ-ын Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Койка)-аас зарласан 2 төрлийн хөтөлбөрт хамрагдах төсөл боловсруулсан.
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт тус хөтөлбөрт туссан шүүгчийн сургалтыг Хүрээлэн хариуцан зохион байгуулах талаар саналаа бэлтгэн хүргүүлсэн.
- Шүүхийн тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам, Шүүгчийн сургалтын 2022-2024 оны нэгдсэн бодлогод нийцүүлэн багц цаг тооцох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан.

9.2. Дотоод сургалт

Шүүхийн судалгааны төв нь 2023 оны 05 дугаар сараас эхлэн сар бүр тогтмол дотоод сургалтыг зохион байгуулан ажилласан. Энэ хугацаанд нийт 6 удаагийн дотоод сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус төвийн судлаачдаас гадна, Хүрээлэнгийн албан хаагчид оролцсон юм.

Хүснэгт 13. Шүүхийн судалгааны төвөөс зохион байгуулсан дотоод сургалтууд

№	Зохион байгуулагдах өдөр	Сургалт, семинар тавих хүний нэр	Сэдэв
1	5 сарын 11	Судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн	Судалгааны арга зүй
2	6 сарын 12	Судалгааны төвийн судлаач З.Янжинлхам, О.Тэнхлүүн	2023.06.02-ны өдөр Хууль зүйн яаманд зохион байгуулагдсан "Хууль тогтоомжийн тухай" хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг танилцуулах сургалт
3	8 сарын 18	Шүүгч С.Отгонтуяа	Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог
		Шүүгч Б. Батаа	Эрүүгийн хэргийг шүүхийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог

4	10 сарын 6	Захиргааны эрх зүйн секторын эрхлэгч С. Цэрэндолгор	Төслийн менежментийн сургалтад суусан туршлагаа хуваалцах нь
5	10 сарын 13	Судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн	Судалгааны арга зүй, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлалууд, судалгааны төвд судалгаа хийхдээ анхаарах зүйлс /шинээр ажилд орсон судлаачид хамрагдсан/
6	11 сарын 17	Шүүгч Ж.Оюунтунгалаг	Судалгааны арга зүй
7	12 сарын 25	Төвийн судлаач: С.Жансая П.Эрхэмбаяр Р.Ануурад	2023.12.08-ны өдөр Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооны дэргэдэх Байгаль орчны эрх зүйн дэд хорооноос санаачилсан “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга” сэдэвт хэлэлцүүлгийг танилцуулах сургалт

9.3. Судалгааны санг төрөлжүүлэн, ангилах ажил

Шүүхийн судалгааны төвийн хийж гүйцэтгэсэн судалгаа, лавлагааг нээлттэй байршуулах буюу Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн цахим хуудасны “Судалгааны бүтээл” хэсэгт Нээлттэй байршуулах болон Хаалттай байршуулах буюу Шүүгчдийн цахим сургалтын системийн “Цахим номын сан” хэсэгт зөвхөн шүүгч нарт зориулан байршуулах судалгаа гэсэн ангиллаар ангилсан.

Иргэний эрх зүйн секторын Нээлттэй байршуулах судалгаа 17, Зөвхөн шүүгч нарт зориулсан 4 судалгаа, Захиргааны эрх зүйн секторын Нээлттэй байршуулах 2 судалгаа, Зөвхөн шүүгч нарт зориулсан 13 судалгаа, Эрүүгийн эрх зүйн секторын нээлттэй байршуулах 16 судалгаа, Зөвхөн шүүгч нарт зориулсан 14 судалгаа байна.

Үүнээс одоогоор ШССМХ-ийн цахим хуудасны “Судалгааны бүтээл” хэсэгт 2 судалгаа, Шүүгчдийн цахим сургалтын системийн “Цахим номын сан” -д **нийт 11** судалгаа тавигдаад байна.

9.4. Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцох хүрээнд

Шүүхийн судалгааны төвийн сектор болон судлаач нар дараах эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулж, илтгэл хэлэлцүүлэх байдлаар оролцсон.

1. Эрүүгийн эрх зүйн сектор нь “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны дэг болон шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал, журмын төсөл” хэлэлцүүлэг: ажлын хэсгийн гишүүнээр томилогдож, тус аргачлал журмын төслийг боловсруулж, ажлын хэсгийн хэлэлцүүлэгт гарсан саналыг үндэслэн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж, төслийн сүүлийн хувилбарыг хянаж, нийт шүүгчийн хуралдааны тогтоолын төслийг бэлдсэн.

Хэлэлцүүлэгт Хууль зүй дотоод хэргийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтэс,

дүүргүүдийн прокурорын газрын прокурорууд, Хууль зүйн туслалцааны төв, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбооноос 50 гаруй төлөөлөл оролцсон. Мөн орон нутгийн шүүхийн шүүгчид цахимаар оролцсон юм.



2. Иргэний эрх зүйн сектор нь УДШ-ийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаагийн “Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл эмхэтгэл”-ийг танилцуулах арга хэмжээнд зохион байгуулагчаар оролцсон.
3. Иргэний эрх зүйн секторын судлаачид “Өв залгамжлагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол, түүний эрх зүйн хамгаалалт” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын хүрээнд “Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг өв залгамжлан авахтай холбоотой шүүхийн практикт хийсэн дүн шинжилгээ” болох үндсэн сэдвийг сонгон авч, илтгэл хэлэлцүүлсэн.


9.5. Бусад хурал, хэлэлцүүлэг, сургалтад хамрагдсан байдал

Шүүхийн судалгааны төвийн судлаачид нь дангаар болон хамтаар хамрагдсан сургалт, хурал, хэлэлцүүлгээс дурдвал:

1. ШССМХ, Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан “Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт” сургалт;
2. УДШ-ийн Тамгын газраас зохион байгуулсан “Шүүхийн практик судлал” хэлэлцүүлэг;
3. МУҮХЦ, БНХАУ-ын Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн их хурлын Үндсэн хууль, хууль зүйн хорооны хамтарсан сургалт;
4. Харьцуулсан Үндсэн хуулийн эрх зүй: Ардчилалд тулгарч буй сорилт хэлэлцүүлэг;

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас зохион байгуулсан “Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэг;
6. УДШ-ийн Тамгын газрын 2022-2023 оны сургалтын хөтөлбөрийн хүрээнд “Кибер аюулгүй байдал” сэдэвт сургалт;
7. Япон улсын Нагояа дүүргийн шүүхийн шүүгч Киоко Цүшимагийн “Япон улсын эрүүгийн шүүхээс ялын хэмжээг сонгон хэрэглэх арга зүй” сэдэвт лекц сургалт;

Япон улсын эрүүгийн шүүхээс ялын хэмжээг сонгон хэрэглэх арга зүй сургалтын үеэр



8. “Монгол Улс дахь хүний эрхийн тулгамдсан зарим асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурал;
9. УДШ-ээс санаачлан зохион байгуулсан “Сэжигтнийг баривчлах ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлэг;
10. Нээлттэй нийгэм форумас зохион байгуулсан “Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хэрэгт оногдуулж буй ялын бодлого, урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт хэлэлцүүлэг;
11. Улсын дээд шүүхэд зохион байгуулсан Европын холбооны техникийн туслалцаа, мэдээлэл солилцох хөтөлбөр (TAIEX)-тэй туршлага солилцох уулзалт;
12. Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч Т.Азжаргалын “Хууль зүйн хариуцлага” нэг сэдэвт бүтээлийн нээлтийн ёслолын арга хэмжээ;
13. Хүний эрхийн нэр томъёонд тодорхойлолт боловсруулах нь судалгааны ажлын хэлэлцүүлэг;

9.6. Илтгэл бичих, сургалт бэлтгэх, албан бичигт хариу хүргүүлэх ажлын хүрээнд

Шүүхийн судалгааны төвийн судлаачид хамтаар болон дангаар бичсэн илтгэл, сургалт, албан бичгийн төслөөс дурдвал:

1. Нийт шүүгчдийн 2 дугаар чуулганд тавих Ерөнхий шүүгчийн илтгэлийг агуулгын төслийг бэлдсэн. Тодруулбал, “Шүүхийн шинэчлэл: Бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага” илтгэлд Шүүхийн хараат бус бие даасан байдал, шүүхийн засаглал, түүнийг бэхжүүлэхтэй холбоотой асуудлын талаар судлан илтгэл бичсэн.
2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн ажлын хэсэгт томилогдож, шүүх эрх мэдэлтэй холбоотой хэрэгжүүлэх ажиллагааны төсөлд саналаа эцэслэн хүргүүлсэн.
3. Бүх шатны шүүхүүдийн олон нийттэй харилцах асуудал хариуцсан албан хаагчдад зориулсан “Шүүхийн мэдээ, мэдээллийг олон нийтэд үр дүнтэй, шуурхай хүргэх нь” сургалтад “Шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэх аргачлал” сэдвээр сургалт бэлтгэж орсон.



Шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэх аргачлал сургалтын үеэр

4. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс зохион байгуулсан “Шүүхэд хандах эрх: Хяналтын шатны шүүхийн чиг үүрэг, эрх хэмжээ” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд Герман улсын Аусбургийн Их сургуулийн хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Петер Казискегийн тавьсан илтгэлийг англи хэлнээс орчуулсан.
5. Дэлхийн оюуны өмчийн байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд Эрүүгийн хуульд заасан оюуны өмчийн эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг схемчлэн боловсруулсан.
6. УДШ-ийн шүүгч Б.Батцэрэнгийн захиалгаар Нэгдсэн Үндэсний Байгууллагаас хэвлэн гаргасан шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын Зарчмууд хэмээх гарын авлагыг орчуулан хийж гүйцэтгэсэн.
7. УДШ-ийн “Шүүхийн цахим шилжилт”-ийн ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна. Уг ажлын хэсэгт “Гадаадын зарим улс орнуудын цахим мэдээллийн

сангуудаас судалгааны зорилгоор мэдээлэл хайх аргын талаарх харьцуулсан лавлагаа”, “Шүүхийн цахим шилжилтийн хүрээнд цахимаар шийдвэрлэж болох хэрэг маргааны талаарх харьцуулсан лавлагаа”-г хийж гүйцэтгэсэн байна.

8. “Сум, сумдын шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын постерын агуулга, үнэлгээний хуудасны агуулгыг бэлтгэж, илтгэлийг шалгаруулж, шагнал гардуулсан.

Ойн эрдэм шинжилгээний хурлын зар

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх

**ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ
СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН
60 ЖИЛИЙН ОЙН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ**

“Сум дахь сум дундын шүүхэд хэрэг
хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал”

Шүүгч, шүүхийн захиргааны ажилтан та бүхнийг илтгэл хэлэлцүүлж оролцохыг урьж байна.
Шалгарсан илтгэлийг хурлаар хэлэлцүүлж, мөнгөн урамшуулал, батламж олгоно.

ИЛТГЭЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА: 2023.11.15-НЫ 17:30 ХҮРТЭЛ СУНГАЛАА
Хүлээн авах хаяг: Info@jtii.gov.mn

ДҮГНЭЛТ

Сургалтын чиглэлээр

- Сургалтын хөтөлбөрийн хороо 2023 онд 6 удаа хуралдаж, 27 хөтөлбөр хэлэлцсэнээс 22 хөтөлбөр батлагдаж, нэмэлт судалгаа хийхээр 3 хөтөлбөр буцаагдаж, 1 хөтөлбөрийн хүрээнд хэлэлцүүлэг хийхээр шийдвэрлэсэн байна. Дээрх батлагдсан 22 хөтөлбөрийн 59 хувь нь заавал судлах, 41 хувь нь сонгон судлах сургалтын хөтөлбөр байсан.
- Шүүхийн сургалтын төвөөс 2023 онд танхимын сургалт 15, цахим хэлбэрээр 14, хосолсон хэлбэрээр 3, нийт 32 сургалт зохион байгуулсан байна.⁹
- Цахим сургалтын системд 69 контент байршуулснаас 50¹⁰ нь шүүгчийн сургалтын видео хичээл, 6 нь сургалттай холбоотой дүрэм, журам, багц цагийн танилцуулга зэрэг мэдээллийн чанартай богино хэмжээний видео танилцуулга, 13 нь системийг ашиглахтай холбоотой зааварчилгаа байна.
- Системд нийт 507 шүүгч бүртгэлтэй байгаагаас 375 шүүгч тайлант хугацаанд 2022 оны багц цаг олгох сургалтдаа бүрэн хамрагдаж батламжаа хүлээн авсан байна. Харин 2023 онд зохион байгуулахаар төлөвлөсөн 3 видео хичээлийн бичлэг бүрэн хийгдэж дуусаагүй байна.¹¹

Судалгааны чиглэлээр

- "Шүүхийн судалгааны төв" нь бүх шатны шүүх, шүүгчдийг судалгаа, мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд нийт 50 судалгааг хийж гүйцэтгэсэн нь өмнөх он тухайлбал 2022 онд 44 судалгаа, лавлагаа, 2021 оны 15 судалгаатай харьцуулахад нэмэгдсэн байна. Уг 50 судалгааны 43 судалгааг УДШ-ийн шүүгчийн захиалгаар хийж гүйцэтгэсэн бол, Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн захиалгат судалгаа 3, Анхан шатны шүүхийн шүүгчийн захиалгат судалгаа 4 байна. Түүнчлэн тус төвийн секторууд нь ихэвчлэн харьцуулсан судалгаануудыг хийж байгаа нь харагдаж байна. Тус төв нь 2023 онд захиалгат судалгаанаас гадна, тухайн цаг үеийн хууль, эрх зүйн салбарт хөндөгдөж буй асуудлыг сонгон нийт 7 бодлогын болон академик судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал, Захиргааны эрх зүйн секторын хийсэн "Хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн гэх үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэх нь: Монгол Улс ба гадаадын зарим улсын зохицуулалт" сэдэвт судалгааны үр дүнг 2023 оны 09 дүгээр сарын 28, 29-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Нийт шүүгчдийн хоёрдугаар чуулганд ШССМХ-ийн захирал Д.Эрдэнэчимэг нийт шүүгчдэд танилцуулсан юм. Мөн эрүүгийн эрх зүйн секторын хийсэн "Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тодорхойлох арга зүйн талаарх судалгаа" нь цаашид шүүгчдийн сургалтын хөтөлбөр болохоор төлөвлөгдөж байна.
- 2023 онд тус төвд 4 шүүгч судлаачаар ажиллан, "Шүүгч-судлаачийн ажлын удирдамж"-д заасны дагуу эрдэм шинжилгээний өгүүлэл, шүүхийн

⁹ 2022 онд сургалтын хөтөлбөр батлагдаж, 2023 онд зохион байгуулахаар төлөвлөсөн сургалтууд энд багтсан болно.

¹⁰ Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн 2023 оны 2 дугаар сараас шүүгчийн сургалтад цахим систем нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн бөгөөд 2022 онд сургалтын хөтөлбөр нь батлагдаж 2023 онд зохион байгуулсан сургалтууд энд багтсан болно.

¹¹ Сургагч багш нар 12 дугаар сард багтаан бичлэгтээ орно гэж мэдэгдсэн байгаа.

шийдвэрийн хураангуйнуудыг бэлтгэн, сургалтуудыг зохион байгуулсан. Шүүгч-судлаач нарын хийж гүйцэтгэсэн судалгааны ажлыг эмхэтгэн, “Шүүгч-судлаач: судалгааны ажлын эмхэтгэл” Цуврал-1 болгон хэвлэж, олон нийтэд хүргэсэн байна. 2024 оны хувьд “Шүүгч-судлаач: судалгааны ажлын эмхэтгэл” Цуврал-2 -ыг гаргах төлөвлөгөөтэй байна.

Олон нийтийг мэдээллээр хангах чиглэлээр

- Судалгааны төв нь шүүхийн шийдвэрийн үндэслэлийг олон нийтэд ил тод байлгах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын болон гадаад улсын шүүхийн шийдвэрийг орчуулан, хураангуйлдаг билээ. Энэхүү чиг үүргийн хүрээнд нийт **31** шүүхийн шийдвэрийн хураангуйг олон нийтэд хүргэсэн байх бөгөөд энэхүү тоо нь 2022 оны **24** шүүхийн шийдвэрээс өссөн байна. Мөн тус төвийн судлаачдын хураангуйлсан шүүхийн шийдвэрийн хураангуй нь цахим орчинд хандалт өндөртэй байгаа нь нийгэмд тулгамдсан асуудал, олон нийтийн анхаарлын төвд байгаа шүүхийн шийдвэрийг шилж, олон нийтэд хүргэж байгааг илтгэх юм.
- ШССМХ-ийн ажилтнууд, судлаачид нь бусад ажлын хүрээнд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, илтгэл хэлэлцүүлэх, хурал, семинарт оролцох зэргээр мэргэжлийн хүрээнд байнга хөгжих, чадавхжих тал дээр онцгойлон анхаарч байна. Мөн тус хүрээлэнд ирүүлсэн албан бичгийн төслийг бэлтгэх, УДШ-ийн шүүгч нарын илтгэлийн төслийг бэлтгэх, шүүхийн захиргааны ажилтнуудад хандсан сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Сэтгүүл эрхлэн гаргах чиглэлээр

- Монголын төр, эрх зүй сэтгүүлийг эрхлэн гаргах чиг үүргийг судалгааны төв нь хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд 2023 онд нийт 3 дугаарыг эрхлэн гаргаж, 12 сарын 25-ны байдлаар англи хэл дээрх тусгай дугаарыг эрхлэн гаргах ажил явагдаж байна. Тус сэтгүүлд 2022 онд №100, №101 болон №102 гэсэн 3 дугаар гаргаж байсан бөгөөд дугаар бүрд ойролцоогоор **10-11** эрдэм шинжилгээний бүтээл, нийтлэл, орчуулга нийтлэгдэж байсан бол 2023 оны тус сэтгүүлийн дугааруудад **5-6** бүтээл нийтлэгдэж байгаа нь буурсан үзүүлэлттэй байна. Тиймээс ирэх онд илүү олон тооны, чанартай эрдэм шинжилгээний бүтээлүүдийг тус сэтгүүлд хэвлэн, нийтлэх талаар онцгойлон анхаарч, холбогдох ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр

- Тайлант хугацаанд нийт 5 хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажилласан байна. Мөн хугацаанд гадаад томилолтын хүрээнд нийт 8 улсад, давхардсан тоогоор нийт 75 шүүгч, судлаач гадаад сургалтад хамрагдсан байна.
- ШССМХ-д зочилсон нийт 7 улсын төлөөлөгч нарт Монгол улсын шүүхийн систем, хүрээлэнгийн талаар танилцуулга хийж, хамтран ажиллах санал солилцлоо.

Цаашид анхаарах чиглэл

- Шүүхийн сургалтын цахим системийн хөгжүүлэлтийг боловсронгуй болгох, сонгон судлах хичээлийн хөтөлбөрийг илүү олон төрөл, хэлбэртэй болгох тал дээр анхаарч ажиллах
- ШССМХ-тэй хамтран ажиллаж буй шүүгч судлаач, шүүгч сургагч багш нарыг хөгжүүлэх тал дээр анхаарч, төлөвлөгөө гаргаж ажиллах
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаад сургалтад хамрагдах шүүгчдийн тоог нэмэгдүүлэх
- Судалгааны эх сурвалжийн хүрээг нэмэгдүүлж, номын сан, мэргэжлийн студитэй болох
- Монголын төр, эрх зүй сэтгүүлд нийтлэгдэж буй өгүүллийн чанарыг дээшлүүлэх

---o0o---

Хавсралт 1. 2023 онд шүүгч-судлаачаар ажилласан шүүгч нарын нэрс

1. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ж.Оюунтунгалаг 2023.02.06-ны өдрөөс эхлэн 2023.08.06-ны өдөр хүртэл;
2. Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Отгонтуяа нь 2023.02.06-ны өдрөөс эхлэн 2023.08.06-ны өдөр хүртэл;
3. Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Батааг 2023.03.01-ны өдрөөс эхлэн 2023.09.01-ны өдөр хүртэл;
4. Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Володяг 2023.03.01-ны өдрөөс эхлэн 2023.09.01-ны өдөр хүртэл.

Хавсралт 2. Монголын төр, эрх зүй сэтгүүлийн зөвлөлийн шинэчлэгдсэн бүрэлдэхүүн

ШССМХ-ийн захирлын 2022 оны 9 сарын
12-ны өдрийн 12 тоот тушаалын
13 дугаар хавсралт

"Монголын төр, эрх зүй" сэтгүүлийн зөвлөл

Сэтгүүлийн эрхлэгч:

-Шүүхийн сурталт, судалгаа, мэдээллийн
хүрээлэнгийн захирал
/Албаны чиг үүргээрээ/

Гишүүд:

- Ж.Амарсанаа
Академич, Хууль зүйн шинжлэх ухааны
доктор /Sc. D/

- С.Нарангэрэл
Академич, Хууль зүйн шинжлэх ухааны
доктор /Sc.D/

-Ж.Бямбаа
Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

-Г.Банзрагч
Улсын дээд шүүхийн шүүгч, Хууль зүйн
ухааны доктор /Ph.D/, дэд профессор

- Х.Эрдэм-Ундрах
Хууль зүйн ухааны доктор /Dr.jur/

-Д.Цолмон
Улсын дээд шүүхийн шүүгч

-Н.Баярмаа
Улсын дээд шүүхийн шүүгч

-Д.Гангабаатар
Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

-Б.Өлзийсайхан
Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

- Рудольф Хэлмхаген
Холбооны Бүгд Найрамдах Герман улсын
Бавари мужийн Пассау хот дах Мужийн
шүүхийн Ерөнхий шүүгч

- Такахаши Акио
Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

Нарийн бичгийн дарга:

-Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн
хүрээлэнгийн Судалгааны төвийн дарга
/Албаны чиг үүргээрээ/

Хавсралт 3. ШССМХ-нд бүртгэлтэй шүүгч-сургагч багш

№	Харьяалах шүүх	№	Албан тушаал	Өөрийн нэр
Эрүүгийн эрх зүйн шүүгч-сургагч багш				
1.	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	Б.Зориг
2.		2.	Шүүгч	Г.Ганбаатар
3.		3.	Шүүгч	Л.Дарьсүрэн
4.		4.	Шүүгч	Д.Мөнхөө
5.		5.	Шүүгч	Ц.Оч
6.		6.	Шүүгч	Д.Очмандах
7.	Баян-Өлгий аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	С.Өмирбек
8.	Булган аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	Д.Азжаргал
9.	Өвөрхангай аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	Н.Энхмаа
10.	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	Н.Одонтуул
11.		2.	Шүүгч	С.Аюушжав
12.		3.	Шүүгч	Ц.Мөнхтулга
13.	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1.	Шүүгч	Б.Батаа
14.	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	1.	Ерөнхий шүүгч	Д.Баттулга
15.	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1.	Шүүгч	Л.Галбадар
16.	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	Ц.Отгонжаргал
Иргэний эрх зүйн шүүгч-сургагч багш				
17.	Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	Г.Даваадорж
18.		2.	Шүүгч	Э.Золзаяа
19.		3.	Шүүгч	Ж.Оюунтунгалаг
20.	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1.	Шүүгч	Ч.Мөнхцэцэг
21.	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	С.Буд
22.		2.	Шүүгч	Б.Мандалбаяр
23.		3.	Шүүгч	Т.Энхтуяа
24.	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1.	Шүүгч	В.Амартүвшин
25.		2.	Шүүгч	Ж.Лхагвасүрэн
26.	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	Н.Оюунтуяа
27.	Дархан-Уул аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1.	Шүүгч	М.Оюунцэцэг

28.	Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	С.Ганчимэг
29.	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	Р.Уранчимэг
30.	Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1.	Ерөнхий шүүгч	Б.Бямбасүрэн
Захиргааны эрх зүйн шүүгч-сургагч багш				
31.	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	1.	Шүүгч	Н.Долгорсүрэн
32.		2.	Шүүгч	С.Мөнхжаргал
33.		3.	Шүүгч	А.Сарангэрэл
34.	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1.	Шүүгч	Н.Дамдинсүрэн
35.		2.	Шүүгч	Т.Мөнх-Эрдэнэ
36.		3.	Шүүгч	Л.Өлзийжаргал
37.		4.	Шүүгч	Д.Халиуна
38.	Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1.	Шүүгч	С.Оюунгэрэл